

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН  
2018 ОНЫ 02 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2018.03.05

Сүхбаатар сум

**Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:**

**1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:**

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид 02 дугаар сард 1 удаа хуралдаж 5 асуудлыг хэлэлцлээ. Үүнд:

-“Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын 2017 оны үйл ажиллагааны тайлан мэдээлэл

-“Шилэн дансны тухай” хуулийн 2017 оны хэрэгжилтэд аудит хийсэн дүнгийн тухай мэдээлэл

-2018 онд ахуйн зориулалтаар агнах барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай

-Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

-Төрийн дээд одон медалиар зарим иргэдийг шагнуулахаар ирүүлсэн санал уламжлах тухай зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Азийн Хөгжлийн Банкны Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төслийн баг аймгийн ГХУСАЗЗөвлөлтэй хамтран гэрч хохирогчийн хамгаалах байрны техник эдийн засгийн үндэслэл, нийгмийн судалгаа боловсруулах ажлаар энэ сарын 02-03-ны өдрүүдэд тус аймагт ажиллаж, судалгаа хийн сургалт зохион байгууллаа.

Сар шинийн баярыг тохиолдуулан Монгол Улсын Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнагдсан 9, Алтан гадас одонгоор шагнагдсан 27, Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнагдсан 14 иргэнд төрийн дээд шагнал одон медалиг гардуулах ёслолын арга хэмжээг зохион байгууллаа.

**2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:**

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 2018 оны 2-р сарын 21, 22-ны өдрүүдэд тус аймагт ажиллаж, аймгийн удирдлагууд болон ард иргэдтэй уулзалт хийлээ. Уулзалт АДБ-ийн "Сэлэнгийн долгио" чуулга, Мандал сумын “Мөнгөн хараа” чуулгын байранд тус тус боллоо. Иргэдээс тавьсан асуултын дийлэнх нь төрийн шагнал одон тэмдэг үнэгүйдсэн, офшорчдын хөрөнгийг оруулж ирэх асуудлыг түргэвчлэх, банкны хүүг бууруулах, тэтгэврийн зөрүүг арилгах, сум орон нутаг, амьдрал ахуй, ар гэртэйгээ холбоотой олон асуулт санал гаргасан.

Энэ сарын 5-нд аймгийн удирдах ажилтны зөвлөгөөн болж, сумдын Засаг дарга, сургууль, цэцэрлэгийн эрхлэгч, ойн анги, ОНӨААТҮГ-ын дарга нар оролцлоо. Энэ удаагийн зөвлөгөөнөөр аймгийн Засаг даргаас 2017 онд агентлагийн дарга, сумдын Засаг дарга, сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч, ойн анги, ОНӨААТҮГ-ын удирдлагуудтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэн, ололт амжилт, алдаа оноогоо хэлэлцлээ. 2017 оны тэргүүний сумдаар тэргүүн байранд Д.Пүрэвдорж даргатай Хүдэр сум, дэд байранд Г.Бат-Орхон даргатай Орхон сум, гутгаар байранд М.Баярбаатар даргатай Шаамар сум, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагуудаас тэргүүн байранд Ж.Од даргатай аймгийн Эрүүл мэндийн газар, дэд байранд М.Рэгзэдмаа даргатай Ус цаг уур, орчны шинжилгээний газар, гутгаар байранд Ч.Жаргалсайхан даргатай Боловсрол, соёл урлагийн газар тус тус шалгарлаа.

Монгол Улсын Засгийн газраас жил бүр газар тариалан, мал аж ахуйн салбарт гаргасан ажлын үр дүнг дүгнэн "УЛСЫН АВАРГА"-уудыг шалгаруулдаг уламжлалын дагуу эрхэлсэн салбартаа гаргасан ололт амжилтаа бэхжүүлж, үр өгөөжтэй ажиллаж байгаа аваргуудын шагналыг Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбат, Н.Оюундарь, Д.Эрдэнэбат нар гардуулан өгч, хүндэтгэл үзүүлсэн. Хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд аймгийн ИТХ-ын дарга Г.Бямбаа, Засаг дарга Ш.Оргил болон аймаг, сумдын удирдлагуудын төлөөлөл оролцлоо. Монгол Улсын Аварга малчнаар Орхонтуул сумын Баянцогт багийн малчин Дамдаагийн Балдорж, Баянгол сумын Гонир багийн малчин Басангийн Балжинням, Сант сумын Хушаат багийн малчин Жигжидсүрэнгийн Цогтбаатар, Алтанбулаг сумын 3 дугаар багийн малчин Оршихын Оюунчимэг, Зүүнбүрэн сумын Бэлчир багийн малчин Тэгшбаянгийн Бат-орших, Улсын аварга фермерээр Мандал сумын Хэрх багийн фермер Дашнямын Отгонбаяр, Улсын аварга тариаланч хамт олноор Ерөө сумын "Моностойн нуруу" ХХК, Түшиг сумын "Анхтамир" ХХК, Хушаат сумын "Цэгээн хуст" ХХК, "Элит үр" ХХК, Цагааннуур сумын "Ургацын хишиг" ХХК, "Товхонхан" ХХК, Улсын аварга тариаланчаар Орхонтуул сумын тариаланч Батаагийн Эрдэнэтогтох, Түшиг сумын "Бооцын тариа" ХХК-ийн механикжуулагч Даржаагийн Ганболд, Хушаат сумын "Өгөөж Мандал уул" ХХК-ийн механикжуулагч Нямсүрэнгийн Жаргалбат нар шалгарлаа. Мөн аймгийн аваргуудыг тодруулан шагнал гардуулах ёслолын арга хэмжээг энэ сарын 05-ны өдөр аймгийн төвд зохион байгуулсан. 2017 оны аймгийн "Тэргүүний хамт олон"-оор Я.Баттөмөр даргатай Сайхан сумын "Хот тохижилтын газар", "Төрийн захиргааны аварга ажилтан"-аар Онцгой байдлын газрын ахлах мэргэжилтэн Д.Түвшинбаатар, "Боловсролын салбарын аварга ажилтан"-аар Сүхбаатар сумын лаборатори 4-р сургуулийн монгол хэл уран зохиолын багш А.Эрдэнэтуяа, "Эрүүл мэндийн салбарын аварга ажилтан"-аар Сант сумын эрүүл мэндийн төвийн сувилагч Л.Амаржаргал, "Соёл урлагийн салбарын аварга ажилтан"-аар Нийтийн номын сангийн арга зүйч Т.Нарандалай, "Биеийн тамир, спортын салбарын аварга ажилтан"-аар "Таван хан" шатрын клубын дасгалжуулагч Ө.Бат-Очир, "Санхүүгийн салбарын аварга ажилтан"-аар Баруунбүрэн сумын ЗДТГ-ын санхүүгийн албаны дарга Л.Балжинням, "Худалдаа үйлчилгээний салбарын аварга ажилтан"-аар "Халиун Уул" ХХК-ий худалдагч Г.Гантуяа, "Үйлдвэрлэлийн салбарын аварга ажилтан"-аар Сайхан сумын "Хөтөл үржих" ХХК-ий "Сайхны гутал" цехийн эзэн О.Чинбат, "Дэд бүтцийн салбарын аварга ажилтан"-аар "Урсгал Ус" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дулаан хангамжийн инженер М.Лувсан-Очир, "Хууль хяналтын салбарын аварга ажилтан"-аар Цагдаагийн газрын эрүүгийн ахлах мөрдөгч Д.Наран, "Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын аварга ажилтан"-аар Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ойн албаны дарга Г.Цэнгэлзаяа, аймгийн "Сурлагын тэргүүний сурагч"-аар Мандал сумын Улсын тэргүүний 1-р сургуулийн 12б ангийн сурагч Б.Мичидмаа, "Урлагийн тэргүүний сурагч"-аар Сүхбаатар сумын Улсын тэргүүний 2-р сургуулийн 3в ангийн сурагч Ж.Сувд, "Спортын тэргүүний сурагч"-аар Сүхбаатар сумын Улсын тэргүүний 2-р сургуулийн 3б ангийн сурагч Д.Цэлмүүн нар тус тус шалгарсан.

"Аймгийн аварга малчин"-аар Алтанбулаг сумын малчин Ж.Пүрэв, Ерөө сумын малчин Б.Ганзориг, Зүүнбүрэн сумын малчин Л.Лхагвасүрэн, Сайхан сумын малчин Н.Давааням, Сант сумын малчин Ч.Жамсранжав, Түшиг сумын малчин Ж.Нямсүрэн, Цагааннуур сумын малчин Б.Амарсанаа, Баруунбүрэн сумын малчин Б.Гантулга, Жавхланта сумын малчин Д.Чамин-Эрдэнэ, Хушаат сумын малчин Д.Алтансүх, Баянгол сумын малчин Б.Цэгмид, Мандал сумын малчин Н.Амгаланбаатар, "Аймгийн аварга фермер"-ээр Шаамар сумын фермер "Бал бурам бүл", Мандал сумын фермер А.Гантулга, Хушаат сумын фермер Б.Эрдэнэ, Баянгол сумын фермер М.Адъяасүрэн, "Аймгийн аварга тариаланч"-аар Цагааннуур сумын "Ургацын хишиг" ХХК-ий механикжуулагч Б.Батцэнгэл, Цагааннуур сумын "Атар трейд" ХХК-ий механикжуулагч С.Атарсайхан, Цагааннуур сумын "Шаргал тариа" ХХК-ий

механикжуулагч Д.Ууганбаяр, Жавхлант сумын “Хурниад” ХХК-ий механикжуулагч Д.Батсайхан, Хушаат сумын “Хайрхан Оргил” ХХК-ий механикжуулагч Б.Ганбат, Зүүнбүрэн сумын “Гэгээлэг трейд” ХХК-ий механикжуулагч Л.Ганхуяг, “Аймгийн аварга ногоочин”-оор Шаамар сумын ногоочин Б.Элдэв-Очир, Ерөө сумын ногоочин Ц.Наваан, Орхон сумын ногоочин С.Сүхбаатар нарын шилдгүүд тодорч шагналаа гардан авлаа.

2018 оны 2-р сарын 13-ны өдөр аймгийн Спортын ордонд XVII жарны “Тийн унжлагат хэмээх “шороон Нохой жил”-ийн сар шинийн баярт зориулсан үндэсний бөхийн барилдаанд хүчит 32 бөх барилдсанаас Улсын харцага Б.Одгэрэл, Улсын начин Ч.Баянмөнх, Улсын начин Б.Дэлгэрсайхан, Аймгийн арслан Б.Уугандаваа нар шөвгөрч Улсын харцага Б.Одгэрэл түрүүлж Улсын начин Ч.Баянмөнх үзүүрлэсэн. Тус барилдааны үеэр Аймгийн Засаг дарга ахмад бөхчүүд, уяачид, харваачдад хүндэтгэл үзүүлсэн.

“Тийн унжлагат” хэмээх шороон нохой жилийн сар шинийн баярт зориулан “Сэлэнгэд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг аймгийн төвд 2018 оны 02 дугаар сарын 5, 6-ны өдрүүдэд зохион байгуулж, 17 сумын 150 аж ахуйн нэгж, иргэд 200 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээтэй өргөн дэлгэр цар хүрээтэй оролцож, 42,5 сая төгрөгний борлуулалт хийж, ард иргэд, хөдөлмөрчид нийт баялаг бүтээгчдийнхээ бараа бүтээгдэхүүнийг сонирхож, худалдан авалт хийлээ.

Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд ноён Масато Такаока тус аймагт энэ сарын 3-ны өдөр ажиллаж Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн “Өвсний үндэс” хүний аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийн хүрээнд Сүхбаатар сумын Улсын тэргүүний 3-р цэцэрлэгийн өргөтгөлийн байрны их засварын ажлын гэрээнд гарын үсэг зурлаа.

Өвөлжилтийн байдал хүндэрсэн Орхонтуул, Баруунбүрэн, Цагааннуур, Түшиг сумдад аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим хэлтэс, агентлагийн дарга нарын төлөөлөл ажиллаж, өвөлжилтийн байдалтай танилцан, ард иргэдтэй уулзалт зохион байгуулж аймгаас баримталж буй бодлого чиглэлээ танилцуулж, “Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлгийн цогц үзлэг оношлогоо”-г хийж, малчдад өвс тэжээлийн дэмжлэг үзүүлж, орон гэр нь шатаж орон гэргүй болсон амьдралын боломжгүй 4 иргэнийг гэртэй болгож, аймгийн улаан загалмайн хорооноос зарим иргэдэд эд зүйлсийг олголоо.

### **Онцгой байдлын талаар:**

Онцгой байдлын ерөнхий газрын баталсан “Үзвэр үйлчилгээ, соёл урлагийн байгууллагад гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, норм, стандартын хэрэгжилтийг шалгах төлөвлөгөөт шалгалтын удирдамж”-ийн дагуу төлөвлөгөөт шалгалтад Сүхбаатар, Мандал, Сайхан, Баянгол суманд үйл ажиллагаа явуулдаг 24 байгууллага, аж ахуйн нэгжийн объект хамрагдан хяналт шалгалтын ажлыг явуулж үзлэг шалгалтаар 123 зөрчил илрүүлэн зөрчлийг арилгуулахаар заавал биелүүлэх албан шаардлага 21-ийг үйлдэж, байгууллага, аж ахуй нэгжийн удирдлагуудад өгсөн. Хяналт шалгалтын явцад гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн шаардлага биелүүлээгүй 2 иргэнийг 300000 төгрөгөөр торгож захиргааны арга хэмжээ тооцож ажилласан.

“Цагаан сар-гэр хороолол” нэгдсэн арга хэмжээг Сүхбаатар, Мандал, Баянгол суманд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад зохион байгуулж, Баянгол сум дахь Улсын нөөц хүмүүнлэгийн тусламжийн ангийн шатахууны агуулах-1, ШТС-5, сумын халаалтын төв-1 худалдааны төв, хүнсний дэлгүүр-9, зоогийн газар-4, боловсролын байгууллага-3, худалдаа үйлчилгээний 28, төрийн захиргааны 6 бусад 16 нийт 68 аж ахуй нэгж байгууллага хамрагдснаас 214 цорьд өө аюулгүй байдлыг үйлчилгээний 28, төрийн захиргааны 6 бусад 16 нийт 68 аж ахуй нэгж байгууллага хамрагдснаас 58 зөрчлийг аюулгүй байдлыг үйлчилгээний 28, төрийн захиргааны 6 бусад 16 нийт 68 аж ахуй нэгж байгууллага хамрагдснаас 17 мэдэгдэл 84-г бичиж тухайн байгууллагын захирал, дарга нарт гардуулан өгч биелэлтийг нь хангуулсан. Гал түймэр унтраах,

аврах анги, улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн анги, Эрэн хайх, аврах ангийн бие бүрэлдэхүүн гэр хорооллын 654 айл өрхийн иргэнд пийшин зуухны аюулгүй байдал, цахилгаан хэрэгслийн ашиглалт хэрэглээний аюулгүй байдлыг хангах талаар зөвлөмж өгч нийт 2175 ширхэг санамж, зөвлөмж тараасан.

Сумдын Засаг дарга, Тамгын газрын дарга нартай утсаар холбогдож “Цагаан сар” эхэлж байгаатай холбогдуулан малчид, иргэдийн шилжилт хөдөлгөөн ихсэж баталгаагүй зам, гол, усаар гарах, автомашин техникийн бэлэн байдал, шатахууны нөөцийг хангаагүйгээс цасанд суух, төөрөх зэрэг асуудлууд гардаг тул багийн засаг дарга нараар болон хэвлэл мэдээлэл, холбооны хэрэгслээр малчид, иргэдэд сэрэмжлүүлэг, анхааруулга өгч, хариуцлагатай эргүүл жүжүүрүүд гаргаж ажиллахыг анхаарууллаа.

Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг [www.tsag-agaar.mn](http://www.tsag-agaar.mn) сайтаас татан авч орон нутгийн мэдээллийн хэрэгслээр иргэдэд шуурхай хүргэж ажилласан.

2018 оны 02 дугаар сард 13 удаагийн объектын гал түймэр гарч 47.323.000 төгрөгийн хохирол учирсан байна. Дээрх гал түймрийн хэргийг Цагдаагийн байгууллагатай хамтран шалгаж, гал түймэр гарсан тухай акт 8, зөрчлийн тэмдэглэл 3-ийг үйлдэж шийдвэрлэсэн.

Гал түймрийн шалтгаан нөхцлийг судалж үзвэл цахилгааны угсралтын буруугаас 3, пийшин зуух яндангийн цонолтоос 5, ил задгай асгасан үнс нурамнаас 1, лаа дэн тамхи шүдэнзний галаас 1, машин техникийн гэмтэл ашиглалтын буруугаас 1, шалтгаан тогтоогдоогүй 2 удаа тохиолдсон.

#### **Гал түймрийн нөхцөл байдлыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал:**

д/д	Гал түймрийн төрөл	2017 оны 2 дугаар сар	2018 оны 2 дугаар сар	Өссөн, буурсан
1	Объектын	6	13	60 хувиар өссөн

Орон нутгийн ус, цаг уур, орчны шинжилгээний албанаас цаг агаарын нарийвчилсан мэдээллийг авч урьдчилан сэргийлэх талаар факс мэдээ 1-ийг сум орон нутаг, иргэд, аж ахуйн нэгж байгууллагад хүргүүлсэн.

Эрэн хайх, аврах ангийн бүрэлдэхүүн иргэд гол, мөрний мөсөн дээгүүр автомашин, ердийн хөсөг, явганаар зорчихгүй байх, мөн гол мөрний мөс цөмрөх аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор Орхон гол, Сэлэнгэ мөрний бэлчирийн мөсний зузаанд хэмжилт хийн голын эргээр эргүүл жижүүр хийж гол, мөрөн дээгүүр зорчиж буй 11 тээврийн хэрэгсэлтэй, 83 том хүн, 11 хүүхэд нийт 94 иргэний аюулгүй байдлыг хангуулж голын мөсөн дээгүүр гаргаж сэрэмжлүүлэг, ухуулга яриа хийн 100 ш хэвлэмэл материал тараан ажиллалаа.

Болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан сэрэмжлүүлэх мэдээ, мэдээллийг орон нутгийн кабелийн телевизээр-2, сонинд-1, FM радиогоор 2 удаа явуулсан.

Орон нутгийн ус, цаг уур, орчны шинжилгээний албанаас цаг агаарын нарийвчилсан мэдээллийг авч сум орон нутаг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад хүргэн урьдчилан сэргийлэх холбогдох арга хэмжээг авч, үүрэн телефоны MSG SENDER программаар аймгийн болон сумдын Онцгой комиссын гишүүд, багийн Засаг дарга, алслагдсан газар амьдарч буй 128 иргэний гар утсанд 2018 оны 02 дугаар сарын 15, 16, 17, 18-ны өдрүүдэд давхардсан тоогоор 339 удаа мессежээр илгээж сэрэмжлүүлсэн.

#### **Стандарт, хэмжил зүйн ажил үйлчилгээний талаар:**

Үнэт эдлэл худалдан борлуулагч аж ахуйн нэгж, иргэдэд үнэт эдлэлийн сорьцын баталгаажуулалтын талаар мэдээлэл өгөх, зөвлөн туслах үйлчилгээг

удирдамжийн дагуу энэ сарын 6-ны өдөр зохион байгуулж, Сүхбаатар сумын “Сэлэнгэ менежмент” ХХК-ийн Россия супермаркет, Стиль худалдааны төв, “Бялхам” ХХК-ийн Жаргалант дэлгүүр, “Ээж Оюу” ХХК-ийн Оюу дэлгүүр, Сэлэнгэ ОУ-ын худалдааны төвийн 37, 39-р лангуу зэрэг үнэт эдлэл борлуулж буй газруудад “MNS6505:2015 мөнгөн аяга ерөнхий шаардлага” стандартын дагуу шалгалт хийж, сорьцын тэмдэглэл, барааны шошгыг аяганд нааж бэхлээгүй, сорилт шинжилгээний болон жин хэмжээ нь зөрүүтэй байх зэрэг зөрчлүүдийг илрүүлсэн. Мөн аймгийн төвд барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ үзүүлж буй 7 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөллийг хамруулан энэ сарын 9-ны өдөр “Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ. Нийтлэг шаардлага MNS 5274:2017 стандарт, нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлт урамшууллын талаар дэлгэрэнгүй тайлар хийж, хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө мэдээллийг холбогдох хэлтэс, газрууд хамтран хийлээ.

Тайлант хугацаанд Хүдэр, Шаамар, Баянгол, Мандал, Алтанбулаг, Сайхан сумдын 9 аж ахуйн нэгж, иргэний 5 хүнсний дэлгүүр, 1 кафе, 2 караоке баар, 1 биллъярдын үйлчилгээний газарт тохирлын үнэлгээ хийж, тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаатай олгосон.

Орхонтуул сумын “Замбал зоог” ХХК-ий 2 нэрийн 3 бүтээгдэхүүнийг сайн дурын баталгаажуулалтанд хамруулан шинжээчийн дүгнэлт гаргаж, стандартын салбар сангаас 7 аж ахуйн нэгж, байгууллага иргэний 9 нэрийн 27 стандартын захиалгыг авч 9 иргэнийг 9 нэрийн 17 стандартаар хангаж, арга зүйн зөвлөгөө өгсөн.

Мөн Сүхбаатар суманд ажиллах худалдааны газруудын 44 жин, 2 туухайг ээлжит баталгаажуулалтанд хамруулж, Дархан уул аймаг дахь “Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 2 тарифт ухаалаг тоолуур баталгаажуулах ажил 2-р сарын 1-ээс хийгдэж эхэлсэн бөгөөд одоогоор 5000 гаруй тоолуурыг баталгаажуулалтанд хамруулаад байна.

### **Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:**

#### **1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:**

2018 оны 2 дугаар сарын 25-ны байдлаар төсөвт байгууллагын 988 баримтаар 8,537,9 сая төгрөгийн гүйлгээ хийж, төсвийн байгууллагуудын санхүүжилтийг тавьж олгосон.

2017 оны төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлан нэгтгэх үйл ажиллагааны хүрээнд батлагдсан удирдамж, хуваарийн дагуу Орхонтуул, Сант, Баруунбүрэн, Цагааннуур, Орхон, Түшиг сумдын санхүүжилтийн тооцоог хийн, санхүүгийн тайлан нэгтгэлийг урьдчилсан байдлаар хянаж байна.

Аж ахуйн нэгж, байгууллагын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг цахимаар авч тайлангийн ирц 90,8 хувьтай нэгтгэгдэж, баталгаажуулан ажиллалаа.

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
<b>1. Орон нутгийн төсвийн нийт орлого</b>		<b>6,285,382.3</b>	<b>8,860,071.1</b>	<b>141.0</b>
1.1	<b>Орон нутгийн төсвийн орлого</b>	<b>1,049,147.6</b>	<b>1,138,376.1</b>	<b>108.5</b>
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	750,195.1	658,095.8	87.7
	Сумдын төсвийн орлого	298,952.5	480,280.3	160.7
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	700,000.0	700,000.0	100.0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	3,918,156.2	3,918,156.2	100.0
1.4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	213,982.6	213,982.6	100.0

1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	276,510.0	2,761,970.3	998.9
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	127,585.9	127,585.9	100.0
<b>2. Орон нутгийн төсвийн нийт зарлага</b>		<b>6,285,382.3</b>	<b>3,581,130.4</b>	<b>57.0</b>
2.1	<b>Орон нутгийн төсвийн нийт зарлага</b>	<b>6,285,382.3</b>	<b>3,581,130.4</b>	<b>57.0</b>
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	969,101.7	273,675.8	28.2
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	101,989.0	-	-
	<b>Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага</b>	<b>1,291,694.0</b>	<b>759,622.5</b>	<b>58.8</b>
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	50,000.0	-	-
	Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалт	-	-	-
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	149,017.3	-	-
	Халамжийн сан	747,952.0	549,834.3	73.5
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	314,724.7	201,988.2	64.2
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	30,000.0	7,800.0	26.0
	Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	3,644,352.9	2,325,186.8	63.8
	Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	278,244.7	222,645.3	80.0
<b>3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг</b>		<b>4,593,407.2</b>	<b>4,593,407.2</b>	<b>100.0</b>
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	461,268.4	461,268.4	100.0
3.2	<b>Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг</b>	<b>110,433.0</b>	<b>110,433.0</b>	<b>100.0</b>
	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	10,944.1	10,944.1	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд	-	-	-
	Хөрөнгө оруулалтын зардалд	99,488.9	99,488.9	100.0
3.3	<b>Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг</b>	<b>103,549.6</b>	<b>103,549.6</b>	<b>100.0</b>
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	103,549.6	103,549.6	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд	-	-	-
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	3,642,868.0	3,642,868.0	100.0
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	275,288.2	275,288.2	100.0
3.6	<b>Тусгай зориулалтын шилжүүлэг</b>	<b>3,918,156.2</b>	<b>3,918,156.2</b>	

	<b>/салбараар/</b>			<b>100.0</b>
	- Ерөнхий боловсролын сургууль	1,853,568.2	1,853,568.2	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	1,024,047.0	1,024,047.0	100.0
	- Соёлын байгууллага	297,466.2	297,466.2	100.0
	- Биеийн тамир спортын байгууллага	132,762.5	132,762.5	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	537,217.9	537,217.9	100.0
	- Газрын кадастрын байгууллага	38,700.5	38,700.5	100.0
	- Хүүхдийн байгууллага	34,393.9	34,393.9	100.0
<b>4. Тусгай сангуудын зарлага</b>		<b>3,831.4</b>	<b>-</b>	<b>-</b>
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	3,831.4	-	-

## 2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2018 I- сар	2018 II- сар	<u>2018-I</u> <u>2018II</u> /төгрөгөөр/
<b>1.ХҮНСНИЙ БАРАА</b>				
<b>1</b>	<b>ТАЛХ, ГУРИЛ, БУДАА</b>			
	Гурил /савласан, кг/	1 400	1 400	
	Талх /орон нутгийн, ш/	1 100	1 100	
	Нарийн боов /кг/	2 500	2 400	-100
	Будаа /кг/	2 400	2 400	
	Элсэн чихэр /кг/	2 600	2 300	-300
<b>2</b>	<b>МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН</b>			
	Хонины мах /кг/	5 000	5 000	
	Үхрийн мах /кг/	5 500	5 600	+100
	Адууны мах /кг/	5 500	5 500	
	Ямааны мах /кг/	5 000	4 600	-400
	Дотор мах, цувдай /цусгүй/	3 000	3 000	
	Хиам /чанасан, кг/	12 000	11 000	-1 000
<b>3</b>	<b>СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ</b>			
	Сүү /задгай, л/	1300	1400	+100
	Сүү / савласан, л/	2 600	2 500	-100
	Тараг /задгай, л/	1 800	1 800	
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	13 000	13 000	
	Айраг /л/	3 500	3 500	
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 000	4 000	
	Өндөг /ш/	320	320	
<b>4</b>	<b>БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС</b>			
	Ургамлын тос /л/	3 800	3 700	-100
	Өөхөн тос /кг/	1 800	2 000	+200
	Шар тос /кг/	13 000	12500	-500

	Масло /задгай, кг/	5000	4800	-200
<b>5</b>	<b>ХҮНСНИЙ НОГОО</b>			
	Төмс /кг/	1 000	1 000	
	Лууван /кг/	1 400	1 400	
	Манжин /кг/	1 500	1 300	
	Байцаа /кг/	1 500	1 500	
	Сонгино /кг/	1 500	1 500	
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	4 500	3 300	-1200
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2 800	2 600	-200
<b>7</b>	<b>ШАТАХУУН</b>			
	Бензин А - 80	1 480	1 580	+100
	Бензин А - 92	1 630	1 650	+20
	Дизелийн түлш	1 720	1 820	+100

### Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу аймгийн хэмжээний хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагч 234 албан тушаалтан хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаанд гарган баталгаажуулж, нэгдсэн тайланг Авлигатай тэмцэх газрын Хяналт, шалгалт, дүн шинжилгээний хэлтэст хүргүүлсэн. Мөн нотариатчийн үүргийг хавсран гүйцэтгэж буй сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын 2017 онд сумын иргэдэд үзүүлсэн нотариатын үйлчилгээний судалгааг авч нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлснээс гадна тус аймгийн Ерөө сумын Бугант тосгоны захирагчид нотариатчийн үүргийг гүйцэтгэх эрх олгуулах саналыг хүргүүлэн шийдвэрлүүлээ.

Эрх зүйн албан бус сургалт сурталчилгааны ажлын хүрээнд “Хорихоос өөр төрлийн ялын тухай ойлголт”, “Нийтэд тустай ажил хийх ялын тухай ойлголт”, “Аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар батлах тухай” 2011 оны 158 тоот тушаал, Хөдөлмөрийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжууд зэрэг сэдвүүдээр сургалт, сурталчилгааны ажлуудыг Алтанбулаг, Баянгол, Мандал, Хүдэр, Зүүнбүрэн, Жавхлант, Орхонтуул, Хушаат сумдад зохион байгуулж нийт 978 иргэн хамрагдсан байна.

2018 оны эхний 3-р сарын 01-ний байдлаар гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 139, гэмт хэрэг 108 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс гомдол мэдээлэл 34.7%-иар, гэмт хэрэг нь 8.5%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Тайлант сард Улсын бүртгэлийн үйлчилгээг давхардсан тоогоор 730 иргэнд үзүүлж, 782 иргэнд иргэний үнэмлэх шинээр болон дахин олгож, газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн 241 гэрчилгээ, үл хөдлөх хөрөнгийн 186 гэрчилгээ бичиж, газрын болон үл хөдлөх хөрөнгийн 77 лавлагааг тус тус олгосон байна.

### **Архивын чиглэлээр:**

Төрийн архивын AMS программд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын хөмрөгийн 22 хадгаламжийн нэгжийн 2782 хуудасны баримтын мэдээллийг уншиж заалт 2046, хүний нэр 4929, байгууллагын нэр 264, газарзүйн нэр 1276 -г шивж эх баримттай холбох ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн хөмрөгийн 30 хн-д эрдэм шинжилгээ техник боловсруулалтын ажлыг хийж үдэж хавтасласан. Мөн 30 хадгаламжийн нэгжийн 4222 хуудас баримтыг скайнердаж мастер хувь үүсгэсэн.

Хуучнаар аймгийн “Гурил тэжээлийн комбинат” болон АДБ-ийн Сэлэнгийн долгио чуулга, Эрүүл мэндийн газрын хөмрөгийн түүхчилсэн лавлах, нэр төрлийн заагуур, шилжүүлэх хүснэгт, ном зүйн жагсаалтыг боловсруулж дансны бүдлийг



хангаж хувийн хэрэгт хавсаргасан. Цахимжуулалтын ажлын мэдээ болон дүнг Архивын Ерөнхий газарт хүргүүллээ.

Зураг төслийн 20 баримтыг цэгцэлж нүүрний бичилтыг бичиж хөмрөгт байршуулсан. Мөн “Бат-Хэрэйд” ХХК-ний гүйцэтгэсэн Мандал сумын Хэрх тосгоны 6-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, “Вентана констракшн” ХХК-ний гүйцэтгэсэн Мандал сумын нэгдсэн эмнэлгийн их засварын зураг төслийн баримтыг хүлээн авч бүртгэл акт үйлдсэн.

Иргэд, албан байгууллагын хүсэлтийн дагуу архивын хуулбар нийт 165.Үүнээс: цахимаар 78, цаасан суурьтай баримтнаас 24, мастер хувиас 63, тодорхойлолт 21, цалингийн тодорхойлолт 10, Эхийн одонгийн лавлагаа 1-ийг тус тус гаргаж үйлчилсэн байна.

### **Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:**

#### **1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр:**

Орхон аймагт Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн ивээл дор 02 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Тогтвортой хөгжил-Ерөнхий боловсрол" улсын хоёрдугаар зөвлөгөөнд аймгийн ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежер, Боловсрол соёл урлагийн газрын дарга, мэргэжилтэн 40 хүний бүрэлдэхүүнтэй баг оролцон 4 захирал, 4 багшийн илтгэлийг хэлэлцүүлсэн.

Мөн сарын 06-нд сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарт цаг үеийн ажлын мэдээллээр сургалт семинарыг зохион байгууллаа.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 6 дугаар сургуульд үдийн цай, урлагийн заал, хими, технологийн кабинет бүхий өргөтгөл ашиглалтад орсон бөгөөд нээлтийн үйл ажиллагааг энэ сарын 9-ний өдөр зохион байгууллаа.

“Мэдээлэл, харилцааны технологи- Боловсролд” бага хуралд 2 мэргэжилтэнг хамруулж, “Мэдээлэл, харилцааны технологи-Боловсрол-Гүүр” төслийн хэрэгжилт болон орон нутагт хэрэгжүүлж ажиллахаар боловсруулсан хичээл, гарын авлагыг ерөнхий боловсролын сургуулиудад хүргүүлж, төслийг орон нутагт хэрэгжүүлэхээр боллоо.

Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх “Ажиглалтын хуудасны программ SUB-2015”- программын хэрэглээг нэмэгдүүлэх, энгийн хялбар болгох үүднээс бүх цэцэрлэгийн багш нарыг оролцуулан онлайн судалгааг зохион байгуулж байна.

Суурь, бүрэн дунд боловсролын түүх нийгмийн ухааны сургалтын чанарыг дээшлүүлэх, төгсөх ангийн сургагчдыг улсын болон элсэлтийн ерөнхий шалгалтанд бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор аймгийн ерөнхий боловсролын 33 сургуулийн 6-12 –р ангийн сурагчдын мэдлэг, чадварын түвшинг тогтоох сорилыг 1-р сарын 30-ны өдөр зохион байгуулж сорилд 6-р ангийн 56 бүлгийн 1480, 7-р ангийн 57 бүлгийн 1410, 8-р ангийн 56 бүлгийн 1401, 9-р ангийн 61 бүлгийн 1508, 10-р ангийн 47 бүлгийн 1003, 11-р ангийн 18 бүлгийн 363, 12-р ангийн 59 бүлгийн 1375 нийт 8540 хүүхэд шалгагдахаас 8091 сурагч хамрагдсан.

УИХ-ын гишүүн Н.Оюундарийн нэрэмжит өсвөрийн шатарчдын аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 17 сумын 20 гаруй клубын 400 гаруй шатарчид өрсөлдөж дүнгээ гаргасан. Багийн дүнгээр “Таван хан” клуб тэргүүн байр, “Бяцхан мастер” клуб дэд байр, Мандал сумын “Чесс” клуб гутгаар байр эзэллээ.

#### **2.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:**

2018 оны 01-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 815 байсан бол 195 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 78 ажлын байранд 33 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 89 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 888 болсон байна.

Нийгмийн халамжийн сангаас 2-р сарын байдлаар 14961 иргэнд 1,648,228,470 төгрөгийг олгоод байна. Үүнд:

-Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2286 иргэнд 341,274,000 төгрөг  
-Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж 1359 иргэнд 88,609,610 төгрөг  
-Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 445 иргэнд 70,024,700  
-Ахмад настны тусламж, хөнгөлөлт 89 иргэнд 18,500,100 төгрөг  
-Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгож буй тусламж хөнгөлөлт 186 иргэнд 7,421,190 төгрөг  
-Жирэмсэн, хөхүүл нярай хүүхэдтэй 2540 эхэд 111,345,000 төгрөг  
-Алдар цолтой ахмад настанд үзүүлэх тусламж хөнгөлөлт 53 иргэнд 8,643,870 төгрөг  
-Эхийн алдар одонтой эхчүүдийн хөнгөлөлт тусламжинд 6785 иргэнд 906,280,000 төгрөг олгосон.

### **3.Эрүүл мэндийн талаар:**

Баруунбүрэн сумын хүн амд “Халуун сэтгэл-2018” явуулын амбулаторын нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг зохион байгуулж үзлэгт нийт 48 өрхийн 307 хүн хамрагдсан. Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн 2018 оны хурлыг 01 дүгээр сарын 30-нд хуралдуулж тусгай зөвшөөрлөө сунгуулахаар хүсэлт гаргасан 20 гаруй байгууллагын асуудлыг шийдвэрлэсэн.

“Миний гэр - аюулгүй орчин” осол гэмтлээс сэргийлэх сарын аяны хүрээнд 8 удаагийн эрүүл мэндийн сургалт, сурталчилгааг хийж 3528 иргэд, эцэг эхчүүд, хүүхэд багачуудыг хамруулсан.

5 хүртэлх насны хүүхдийн золгүй тохиолдлын эндэгдлээс сэргийлэх хурлыг Зүүнбүрэн, Сайхан сумдуудад зохион байгуулж, тус хуралд тойргийн сумдын эрүүл мэндийн төвийн дарга, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, эх баригч, сургууль, цэцэрлэгийн эмч, тухайн сумын Засаг даргын орлогч нарын 90 гаруй хүн оролцсон. Мөн хөхөөр хооллолтын ач холбогдол, зөв хөхүүлэх, өсвөр насны хүүхдийн эрүүл мэндийн байдал, зэрэг сургалтуудыг зохион байгуулсан.

Мандал сумын Хэрх тосгонд Халдварт болон Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж нийт үзлэгт 1914 хүнийг хамруулсан. Уг үзлэгт хамрагдсан хүн амын мэдээллийг цахим санд бүртгэх ажил давхар хийгдэж байна. Олон улсын худалдааны төвийн ажилчид болон Хилийн цэргийн 0101-р ангийн ажилтан албан хаагч, цэргүүдийн дунд “Уушигны эмгэг илрүүлэх үзлэг”-ийг зохион байгуулж нийт 305 иргэдийг хамруулсан. Тус үзлэгээр цээжний зурагт өөрчлөлттэй илэрсэн 9 иргэнээс 4 хүнийг цэрний сорьцын шинжилгээнд хамруулж хяналт тавин ажиллаж байна.

Магадлан итгэмжлэлийн хугацаа дууссан Жавхлант, Хүдэр, Ерөө, Хушаат, Цагааннуур, Шаамар, Алтанбулаг, Бугант тосгоны Эрүүл мэндийн төвүүдийн магадлан итгэмжлэлийн материалыг бүрдүүлэн авч Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлсэн.

### **4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:**

Дэлхийн зөн Монгол Олон байгууллага, Сайхан сумын Засаг даргын Тамгын газартай хамтран “Хамтарсан багийг чадавхжуулах” сургалтыг зохион байгуулж сургалтанд 9 сумын 78 хамтарсан багийн гишүүд хамрагдлаа.

Залуу гэр бүлийг дэмжих, Монгол зан заншлаа эрхэмлэн дээдлэх, гэр бүлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор гэрлэж буй хосуудад “Гэр бүл төлөвлөлт” сэдвээр мэдээлэл хийж, гэр бүлийн тангараг өргүүлэн, гэрлэлтийн баталгаа гардуулах ажлыг зохион байгуулан хүндэтгэлийн танхимаар нийт 5 гэр бүл үйлчлүүлсэн.

Өсвөр үе, залуучуудын хөгжилд сөргөөр нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс “Хуулиа мөрдье-21” аяныг удирдамж чиглэлийн дагуу өрнүүлж аяны хүрээнд “Согтууруулах ундааны хор уршиг”, “Дэлгэцийн донтолт” сэдвээр Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Ерөнхий боловсролын сургуулийн 200 гаруй сурагчдыг

хамруулан сургалт зохион байгуулж, ерөнхий боловсролын 4 сургуулийн нийгмийн ажилтан, сурагчид оролцсон дэвжээ тэмцээн зохион байгуулж, шагнаж урамшууллаа.

Аймгийн Хүүхдийн нэгдсэн зөвлөлөөс санаачлан өвөлжилт хүндэрсэн сумдуудад “Сэтгэлийн өглөг” сайн үйлсийн аяныг өрнүүлж хандиваар цугларсан эд зүйлсийг Орхонтуул сумын Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өглөө.

Аймгийн Нийтийн номын сантай хамтран “Үсэг урлалд амилахуй” Монгол бичгийн уралдааныг Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулж уралдаанд 6 сумдаас ирүүлсэн нийт 81 бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж олон нийтэд суралчиллаа.

Өсвөр үеийнхэнд үндэсний хувцасаа дээдлэн хүндэтгэх, сурталчлан таниулах зорилгоор “Дээлтэй Монгол хамт олон” фото зургийн уралдааныг “Цахлай” төсөлтэй хамтран зохион байгуулж 9 сумаас ирүүлсэн 42 фото зурагаар үзэсгэлэн гаргаж шалгарсан хамт олонг шагнаж урамшуулсан.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд 2 дуудлага ирснийг хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэн ажиллалаа.

## **5.Нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар:**

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг 2,1 тэрбум төгрөг бүрдүүлэх төлөвлөгөөтөйгээс 2-р сарын 20-ны байдлаар өссөн дүнгээр 1,4 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж 68,5 хувийн биелэлттэй ажиллаж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 16013 тэтгэвэр авагчдад 4650.33 сая төгрөгийг тэтгэвэрт, Тэтгэмжийн даатгалын сангаас 510 хүнд 159.91 сая төгрөгийг Хөдөлмөрийн чадвараа түр алдсан, Жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 234 хүнд 93.34 сая төгрөг, Ажилгүйдлийн даатгалын сангаас 43 хүнд 68.84 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид олгосон.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоор энэ сард 241 иргэний материалыг хэлэлцэж 7 иргэний актыг цуцалж, 41 иргэн шинээр тогтоолгож, 193 иргэн актаа сунгуулсан.

### **Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас гаргасан "Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP, GHP) нэвтрүүлэх зөвлөмж" хичээл, үзүүлэн, аудио, видеог Мандал, Сүхбаатар, Алтанбулаг, Сайхан, Баянгол, Цагааннуур, Ерөө, Хүдэр, Түшиг сумдын ресторан, кафе, цайны газар, эмнэлэг, сургууль, цэцэрлэг, МСҮТ, дотуур байр, үйлдвэрийн болон албан байгууллага, хорих анги, сувилал, зочид буудал, амралтын газруудын дэргэдэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд зориулан явуулах талаар чиглэл хүргүүлж, аймгийн хэмжээнд нийтийн хоолны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын судалгааг шинэчлэн гаргаж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/27 дугаар захирамжаар аймгийн нөөцөөс 82 тн өвс 4 тн тэжээлийг өвөлжилт хүндэрсэн болон хүндэрч болзошгүй Орхон, Орхонтуул, Баруунбүрэн, Сайхан, Мандал, Баянгол, Сант сумдад хуваарилан малчдад хүргэж, тээврийн зардалд аймгийн Засаг даргын нөөцөөс 22,3 сая төгрөгийн зардал шийдвэрлэж тухайн сумдын малчид, мал бүхий иргэдэд хүргүүлээд байна. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр хуралдааны шийдвэрээр 250 өвс, 200 тн тэжээлийг 50 хувийн хөнгөлөлттэй үнээр хямдруулан олгохоор шийдвэрлэснийг малчдад хүргүүлсэн.

ОХУ-аас малын тэжээл оруулж ирэхээр ХХААХҮ-ийн яамтай гэрээ байгуулсан 3 аж ахуй нэгжээс “Од групп” 20 тн хивэг, “Чансаа холдин трейд” 10 тн хорголжин тэжээлийг Сүхбаатар суманд байршуулан мал бүхий иргэдэд борлуулж эхлээд байна. Дээрхи тэжээлийг Мандал, Баянгол, Сайхан, Сүхбаатар сумдад борлуулах цэг

байгуулан борлуулах саналаа тэжээл оруулж ирэх аж ахуйн нэгжүүдэд хүргүүлээд байна.

Аймгийн хэмжээнд 2018 оны 02 дугаар сарын байдлаар нийт 1232 тогой мал хоргодоод байгаагаас бод 332, бог 900 толгой байна. Үүнээс Адуу- 60, үхэр- 272, хонь 432, ямаа 468 байна.

Зүүнбүрэн сумын 2-р баг Охиндий гэх газарт үхрийн шүлс гоожсон гэх дуудлага ирсний дагуу шуурхай баг гарч газар дээр нь түргэвчилсэн тестээр хариу сөрөг гарсныг баталгаажуулах шинжилгээнд дээж авч УМЭАЦТЛ-т илгээсэн ба шинжилгээний хариу сөрөг гарсан. Мөн Алтанбулаг, Цагааннуур сум, Аймгийн цагдаагийн газраас ирүүлсэн нийт 7 дээжинд нян судлалын шинжилгээг хийж халдваргүй болохыг тогтоож хариуг хүргүүлсэн.

Цагааннуур, Зүүнбүрэн, Шаамар, Алтанбулаг зэрэг сумдаас Сүхбаатар сумын худалдааны төв, нийтийн хоолны газарт нийлүүлэгдэж буй МАА-ны гаралтай мах, махан бүтээгдэхүүний үхрийн 3429 кг махны 27 дээж, хонины 1863 кг махны 69 дээж, ямааны 44 кг махны 2 дээж, адууны 369 кг махны 3 дээж, 600 л сүүний 1 дээжинд АЦ-ийн магадлан шинжилгээ хийж гэрчилгээ олгосон.

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2019 оны захиалгыг хийж, МЭҮН-үүдээс 2018 оны өрх бүртэй хийсэн товчоог гаргуулан авч нэгтгээд байна.

### **Зургаа. Хөрөнгө оруулалт, газрын харилцааны хүрээнд:**

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас ирүүлсэн чиглэлийн дагуу аймгийн орон нутгийн өмчит байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн тайланг "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д шивж оруулах ажил хийгдэж байгаа бөгөөд 80 хувьтай явагдаж байна. Мөн орон нутгийн өмчит нийт 227 байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайлантай үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайланг тулган баталгаажуулах ажлын явц 30 хувийн гүйцэтгэлтэй байна.

2018 оны худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөнд орсон ажлуудаас 10 ажлын зураг төсөвийг цахим хэлбэрээр зарлан хүлээн авах шатандаа явагдаж байна. Үүнд:

- 1.Ерөө сумын сургуулийн спорт заалны шалны засвар,
- 2.Орхонтуул сумын ЗДТГ, соёлын төвийн дээвэр засвар,
- 3.Шаамар сумын ЗДТГ-ын байрны их засвар,
- 4.Ерөө сумын 1-р багийн Энхтал хэсгийн шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамж, дэд станц,
- 5.Ерөө сумын 2-р багийн Дарь эх хэсгийн шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамж, дэд станц,
- 6.Хүдэр сумын Тарвагатай 1-р багт 04 квт-ын шугам татах,
- 7.Зүүнбүрэн сумын сургуулийн дээвэр засвар,
- 8.Сант сумын соёлын төвийн их засвар,
- 9.Аймгийн Нэгдсэн эмнэлгийн поликлиник засвар,
- 10.Баруунбүрэн суманд гүний худаг гаргах

Газрын даамлуудтай 2018 оны үр дүнгийн гэрээ байгуулах, Аймгийн 2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт, газрын харилцааны үйл ажиллагааг хангахад талуудын оролцоог тодорхойлох, хамтын ажиллагааг сайжруулахаар "Газрын даамлуудын нэгдсэн сургалт" семинарыг 2018 оны 02 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд зохион байгуулав. Тус сургалтаар 15 сумын 17 газрын даамлууд мөн Бугант тосгоны газрын асуудал хариуцсан мэргэжилтэн хамрагдлаа.Мөн сумдын газар орны нэрийн зургийг тоон хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Алтанбулаг, Түшиг, Цагааннуур, Хөтөл, Жавхлант, Баянгол, Хүдэр, Шаамар, Орхон, Орхонтуул, гэсэн 10 сумын нэрийн зургийг тоон хэлбэрт шилжүүлж дууссан.

Аймгийн төв Сүхбаатар сумын 8 багийн Засаг дарга болон нийгмийн ажилтан, багийн хэсгийн ахлагч нартай хамтран сумын 2018 оны газар зохион байгуулалтын

төлөвлөгөөг танилцуулж, 420 иргэнд мэдээлэл хүргэж, газрын тухай хуулиар сургалт зохион байгуулж ажиллалаа.

### **Долоо. Байгаль орчин**

2018 оны 02-р дугаар сарын 1-нд тус аймгийн зүүн өмнөд хэсгээр, 8, 13-нд ихэнх сумдын нутгаар, 9-нд хойд хэсгээр, 10-нд зүүн хэсгээр, 0,0-3,0 мм цас орсон. Орхон, Бугант, Баруунбүрэн, Орхонтуул, Хүдэр, Баянгол, Мандал сумдын нутгаар 8-23 см, цасны нягт 0,16-0,24 г/см<sup>3</sup>, бусад сумдын нутгаар 1-7см, нягт 0,17-0,18 г/см<sup>3</sup> байна. Өвөлжилт хүндэрсэн сумдын 4 зүгт хийсэн хэмжилтээр Орхонтуул 18-30 см, Баруунбүрэн 11-28 см. Орхон 7-9 см зузаан цастай байна. Цасны нягт дунджаар Орхонтуул, Баруунбүрэн суманд 0.15-0.34г/см<sup>3</sup>, хунгарласан газартаа 20-73 см, хөрийн зузаан 4-26 см хүртэл хатуурч нягтаршсан байна.

Ихэнх хугацаанд салхи баруун болон баруун хойноос 5-10 м/сек байв. 13-нд нийт нутгаар салхи түр зуур ширүүсч 11-16 м/сек хүрсэн.

3, 5-7, 11, 14-17 хооронд хүйтэрч шөнөдөө 25-30 градус, өдөртөө 14-19 градус хүйтэн байсан бол 6, 7, 13, 18-20 хооронд дулаарч шөнөдөө 18-23 градус, өдөртөө 5-10 градус хүйтэн байв. Бусад хугацаанд шөнөдөө 20-25 градус, өдөртөө 10-15 градус хүйтэн байлаа.

Сэлэнгэ мөрний мөсний зузаан Зүүнбүрэн сум орчмоор 100 см Сүхбаатар сум орчмоор 58 см, Орхон голын мөсний зузаан Орхон сумаар 140 см, Сүхбаатар сумаар 80 см байгаа бол Ерөө голын мөсний зузаан Ерөө сумаар 105 см, Дулаанхан сумаар 105 см байна. Хараа голын мөсний зузаан Баянгол сум орчмоор 121 см Хүдэр голын мөсний зузаан Хүдэр сумаар 86 см байгаа бол Зэлтэр голын мөсний зузаан Түшиг сумаар 73 см байна.

Монгол орны UN-REDD үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй “Ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн ойн тогтвортой менежмент төлөвлөгөөг орон нутагт танилцуулах семинар, хэлэлцүүлэг”-т хамрагдаж аймгийн Ойн менежмент төлөвлөгөөний 2018-2022 оны төсөлд санал өгсөн. Мөн REDD+ хөтөлбөрийн хүрээнд “Ойн хомсдол доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах нь” сургалтыг зохион байгуулж, 17 сум 6 тосгоны байгаль хамгаалагчид, сумын болон сум дундын Ойн ангийн нийт 50 гаруй хүн хамрагдлаа.

Сэлэнгэ аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны Шүүхийн шүүгчийн 2018 оны “Хүсэлт шийдвэрлэх тухай” 25 тоот захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүгийн хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан 4.5 тн бүхий “Дэрвэгэр жиргэрүү” ургамлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу худалдан борлуулах ажлыг зохион байгуулж ажилласан. Шалгарсан “Экопетролиум” ХХК-д 1 кг-ийг 10,000 төгрөгөөр тооцон 4500 кг-ийг 45 сая төгрөгөөр худалдан борлуулж аймгийн төсөвт төвлөрүүлсэн.

### **Найм.Сум орон нутгийн талаар**

#### **Алтанбулаг сум:**

“Хуулиа мөрдье-21” арга хэмжээний мэдээлэл бүхий тараах материал, зурагт хуудсыг худалдаа үйлчилгээний 17 аж ахуй нэгж байгууллагад танилцуулж, арга хэмжээний талаар мэдээлэл өгч согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг байгууллагуудад Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн сурталчилгаа, дагаж мөрдөх дүрэм журмын талаарх мэдээлэл бүхий зурагт хуудас /плакат/-ыг худалдаа үйлчилгээний газруудад нааж байршуулан, хамтран ажиллах, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг зөвлөв.

Сталинградын ялалтын 75 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлж, аймгийн ахмадын хороо, ОХУ-ын Буриад Улсын Хиагтын районы ахмадын хороо, Алтанбулаг сумын ахмадын хороо, Хилийн 0101 дүгээр ангийн ахмадын хороо хамтран ахмад дайчид хүүхэд залуучуудын уулзалтыг зохион байгуулж, ахмад хилчин

Ч.Бира-д "Дайны үеийн хүүхэд" дурсгалын медаль гардуулж, Б.Ринчингийн нэрэмжит дунд сургуулийн номын санд эх орны дайны холбогдолтой фото цомог, ном зэргийг дурсгалаа. Энэ үеэр Орос, Монголын ахмадуудад зориулж хилчин дайчид ая дууны мэнд дэвшүүлж, Алтанбулагт суманд байрлах Зөвлөлтийн дайчдын хөшөөнд цэцэг өргөж, ойд зориулан гаргасан зурагт самбарын нээлт боллоо. Мөн сарын 2-нд ОХУ-ын Буриад Улсын Хиагт хотод болсон Аугаа их эх ороны дайны Сталинградын орчинд зөвлөлтийн арми Гитлерийн фашистуудыг бут цохисон түүхэн ялалтын 75 жилийн ойг тэмдэглэх баярын үйл ажиллагаанд аймгийн ахмадын хорооны төлөөлөгчид оролцлоо.

Аймгийн төвд 2-р сарын 05-06 өдрүүдэд зохион байгуулагдсан "Сэлэнгэд үйлдвэрлэв" үзэсгэлэн худалдаанд сумын малчид, ногоочид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид сүү, цагаан идээ, хүнсний ногоо, даршилсан бүтээгдэхүүн, гар урлал зэрэг сумандаа үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээрээ оролцож сая гаруй төгрөгийн борлуулалт хийсэн.

"Улсын Аварга малчин"-аар аймгийн аварга малчин Оршихын Оюунчимэг тодорч, 01 дүгээр сарын 31-ний өдөр УИХ-ын гишүүн Н.Оюундарь болон аймаг, сумын удирдлагуудын хамт шагналыг гардуулсан.

СӨБ-аас ардын ёс заншлаас суралцах, хүүхдүүдийг Монгол ардын тоглоом наадгайгаар тоглуулж сургах, эцэг эхчүүд нэг дор цуглан бие биеэ ойлгон, чин сэтгэлийн халуун дотно яриа өрнүүлэх, хамтаараа асуудлыг шийдвэрлэх, тусалдаг нэгэн хамт олон болж чадах зорилгоор дунд, ахлах, 2 бэлтгэл бүлгийн хүүхэд, эцэг эх, багш оролцсон "Дөрвөн бэрх" тэмцээн явуулсан. Мөн сар шинийн баярыг угтаж "Энх мэндийн хадаг" өглөөлөг явуулж, хүүхдүүд багш нар үндэснийхээ дээл хувцсаар гоёж ардын дуу, шүлэг, бүжгээр ая дууны мэндийг өргөж, хүүхдүүдийн дунд АХА тэмцээн, Морь уралдуулах, бөхийн барилдааныг зохион байгуулсан.

ЕББДСургуулиас "Эх хэлээ дээдэлье" төслийн хүрээнд бага ангийн сурагчдад ардын уламжлалт тоглоом наадгайгаар тоглож сурах, сургах ажлыг дэмжин эцэг эхчүүд анги бүрт шагай, шагайн уут, олбогтой болгосон. "Шагайн наадгай" тэмцээнд 1-р анги Морь уралдуулах, 2-р анги Шагай таалцах, 3-р анги Алаг мэлхий өрөх, 4-р анги Шагай шүүрэх, 5-р анги Дөрвөн бэрх буулгах төрлүүдээр амжилттай оролцлоо.

Мөн төслийн хүрээнд хүүхдийг монгол хэлний үгсийн сангаар аялуулж, эх хэлээрээ бахархах, уран яруу унших чадварыг дээшлүүлэх зорилгоор зохион явуулсан "Уран үгсийн чуулган" шүлгийн наадамд 1-5-р ангийн 403 сурагч, хүүхэдтэйгээ хамт хөгжсөн 284 эцэг эх оролцсон.

Сумын эрүүл мэндийн төв "Бага насны хүүхдийг осол гэмтлээс сэргийлье", "Бага насны хүүхдийг түлэгдлээс сэргийлье", "Хөлдөлт" зэрэг сэдэвт сургалтыг төр төсвийн 5 албан байгууллагын 250 эцэг эхчүүд болон асран хамгаалагч нарт явуулж 2 төрлийн 250 ширхэг гарын авлагыг тарааж ажилласан.

Нэгдсэн музей, Соёлын төв хамтран 17-р жарны Тийн унжлагат хэмээх шороон нохой жилийн сар шинийн баярыг угтан сумынхаа албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн дунд 2018.02.09-ний өдөр "Дөрвөн бэрх" уламжлалт ёс заншлын уралдаант тэмцээн зохион байгуулж 8 баг авьяас билгээ сорин өрсөлдөж Тэргүүн байранд Найрамдал цэцэрлэгийн баг Дэд байранд ЗДТГ-ын баг, Гутгаар байранд Ахмадын хорооны баг оров.

### **Баруунбүрэн сум:**

Тус суманд үйл ажиллагаа явуулж байгаа 3 мал эмнэлэг, үржлийн нэгжийн 2017 онд хийсэн ажлын тайлан, мэдээллийг сумын Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн үнэлэлт дүгнэлт гарган хобогдох газарт нь хүргүүллээ.

Малын гоц халдварт Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, гарын авлага материал бэлтгэн Ивэнгийн 1 дүгээр багийн 85, Бургалтайн 2 дугаар багийн 122 өрхөд тараан өгч өвчний шинж тэмдэг илэрсэн тохиолдолд тухайн багийн Засаг дарга, ХАА-н тасаг, малын эмч нарт яаралтай мэдэгдэж шуурхай арга хэмжээ авч ажиллах талаар мэдээллүүдийг өгч ажиллаа. Мөн энэ сарын 15-ны өдөр Орхон

аймгийн Жаргалант суманд малын гоц халдварт “А” зэрэглэлийн шүлхий өвчин гарсантай холбогдуулан тус сумын онцгой байдлын ажлын хэсэг хуралдаж захирамж, шийдвэр гарган сумын төв зам дагуу Цагаан-овооны 3 дугаар багт хяналтын пост ажиллуулж, сумын Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагчид хариуцлагатай жижүүр хийж байна.

Сайхан сумын сум дундын цагдаагийн тасгаас ирүүлсэн экологи эдийн засгийн үнэлгээ тогтоох тухай хүсэлтийн дагуу Сайхан сумын журмын хашаанд хураагдсан хууль бусаар тээвэрлэсэн түлшний модонд экологи эдийн засгийн үнэлгээ тогтоож, “Шинэ-Орос Хийц” ХХК-ний үндсэн ашиглалтаар оруулж ирсэн мод болон Сайхан сумын “Хэт Жолоо” ХХК-ний арчилгааны огтлолтоор орж ирсэн модонд хэмжилт хийж ажиллалаа.

2018 оны 02-р сарын 01-ний өдөр аймгийн Засаг дарга Ш. Оргил сумын иргэдтэй уулзалт зохион байгуулж өвөлжилт хүндэрсэнтэй холбоотой сумын малчдад өвс болон тэжээл тараан өгч аймгийн Улаанзагалмайн хорооноос сумын Ивэнгийн 1-р багийн иргэн Т.Энхтуяа, Бургалтайн 2-р багийн иргэн З.Алтанхүү, Цагаан-овооны 3-р багийн иргэн Ё.Сүхбаатар нарт тусламжийг олгосон.

Төрийн санд 2018 оны 2-р сарын байдлаар орон нутгийн төсвийн орлого төлөвлөгөөгөөр 13639.4 орохоос гүйцэтгэлээр 2320.3 мянган төгрөг орж биелэлт 17.0 хувьтай, туслах үйл ажиллагааны орлого болон үндсэн үйл ажиллагааны орлого төлөвлөгөөгөөр 4550.0 мянган төгрөг орохоос гүйцэтгэл нь 4324.2 мянган төгрөг орж биелэлт 95.0 хувьтай, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт төлөвлөгөөгөөр 230275.3 мянган төгрөг ирэхээс 230275.3 мянган төгрөг ирж гүйцэтгэл нь 100% санхүүжигдсэн. Зардлын гүйцэтгэл нь 179749.9 мянган төгрөг байна.

Орон нутгийн санхүүгийн дэмжлэг төлөвлөгөөгөөр 63563.6 мян.төгрөг ирэхээс гүйцэтгэл нь 63563.6 мянган төгрөг ирээд байна. Санхүүгийн дэмжлэгээс 63563.6 мянган төгрөг, ОНТатварын орлогоос 2320.3 мянган төгрөг, өөрийн орлого 3528.4 мянган төгрөг буюу нийт 56471.5 мянган төгрөгөөр санхүүжүүлээд байна.

“Хуулиа мөрдье-21” архины худалдаа, үйлчилгээнд хяналт тавих нөлөөллийн ажлыг удирдамж, төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, сумын иргэдэд зориулсан Архидан согтуурахтай тэмцэх тухай гарын авлага бэлтгэн хуулийн буланд байршуулж, сумын хэмжээнд согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээ эрхэлдэг аж ахуй нэгжүүдэд улирал бүр хяналт шалгалт явуулж сумандаа 7 хоног бүрийн Мягмар гаригийг Архигүй өдөр буюу согтууруулах ундаа худалдаалахыг хориглосон тухай сумын ИТХ-ын тогтоол болон Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж архинаас хамааралтай этгээд, гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй иргэдийн судалгааг шинэчлэн гаргаж баяжуулалт хийсэн.

### **Баянгол сум:**

Арван долдугаар жарны “Тийн унжлагат” хэмээх шороон нохой жилийн сар шинийн баярт зориулсан 32 бөхийн барилдаан, хүндэтгэлийн хүлээн авалтыг зохион байгуулж сумын 75-аас дээш настай ахмадуудыг хамруулж гарын бэлэг гардуулсан. Мөн “Бахархах түүхтэй Сэлэнгэчүүд” нэвтрүүлэгт Баянгол сумын бахархал болсон 25 ахмад настан оролцож залуу сайхан насандаа хийж бүтээсэн ажил үйлс, туршлагаасаа залуучуудад хуваалцлаа.

“Хуулиа мөрдье-21” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн сурталчилгаа, архины хор хөнөөлийн талаарх мэдээ мэдээлэл бүхий зурагт хуудсыг аялуулж, цагдаагийн хэсгээс согтууруулах ундаа худалдан орлуулах үйлчилгээнд хяналт шалгалтыг зохион байгууллаа.

ЕБС-ийн 12-р анги төгсөх 60 суралцагчид “Мэргэжлээ зөв сонгох нь” сургалтыг зохион байгуулж, элсэлтийн ерөнхий шалгалтанд бэлтгэх талаар зөвлөгөө өгөв. Сургуулийн хүүхэд хамгааллын хороо, хүүхдийн оролцооны байгууллагын чиглүүлэгч нар ахуйн осол гэмтлээс өөрийгөө болон үр хүүхдээ хамгаалах талаар түлэгдэлтэс сэргийлэх, түлэгдэлт үүссэн тохиолдолд анхны тусламж хэрхэн үзүүлэх талаар

зөвлөмж боловсруулан эцэг эхчүүдэд хүргэх, “Хуулиа мөрдье” аяны хүрээнд суралцагчдад Хөдөлгөөний аюулгүй байдал, Зөрчлийн тухай хуулийн талаар сумын Цагдаагийн хэсгээс мэдээлэл, сургалт хийснээс гадна сургалтын үйл ажиллагаа стандартын дагуу хэвийн явагдаж байна.

Сумын цэцэрлэгээс эцэг эх, хүүхэд багачуудад чиглэсэн олон арга хэмжээнүүдийг зохион байгуулсан бөгөөд тухайн сард “Хайраа хуваалцъя”, “Дээлтэй Монгол” өдөрлөг, “Хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлье” сургалт, “Соёлтой зөв хооллоход сургая” үзүүлэх ажил, номын үзэсгэлэн гаргаж ном хандивлах ажлыг тус тус зохион байгуулсан. Мөн Монгол ардын өв уламжлал, ёс заншлаа хүндлэн дээдлэх, ардын тоглоом наадгайн төрлүүд шагай харвах, морь уралдуулах, алаг мэлхий өрөх, шагай няслах зэрэг тоглоомоор өртөөчлөх аргаар тоглууллаа.

Сумын соёлын төвөөс 2018 оныг Ардын авъяастнуудыг дэмжих, соёл урлагийн шинэлэг үйл ажиллагааг зохион байгуулах, ажлчдын хариуцлага сахилга батыг сайжруулах зорилтыг тавин ажиллаж “Эмэгтэйчүүдийн бүтээлч цаг”, Соёл мэдэлэлийн цаг”, Монгол кино урлагийг сурталчлах “Хүн мод” уран сайхны кино зэрэг 7 удаагийн арга хэмжээнд 1220 гаруй иргэн хамрагдсан байна.

Эрүүл мэндийн төв тайлант хугацаанд амбулаториор нийт 506 иргэнийг үзлэгт хамруулж, дээд шатлалын эмнэлэгт 26 иргэнийг онош тодруулахаар илгээж, 296 иргэнд өдрийн эмчилгээ хийж, 61 иргэнийг хэвтүүлэн эмчилсэн. 0-5 насны 86 хүүхдийг жинлэн товлолыг дархлаажуулалтанд 100 хувь хамруулсан.

Сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөцөд байгаа 1300 боодол өвсийг 240 малчин, мал бүхий иргэнд, 10 тонн рапсын хаягдлыг 160 малчин, мал бүхий иргэнд олгож, малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж сэрэмжлүүлгийг 3 багийн 180 гаруй малчин өрхөд хүргэсэн.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь олгож, цалинтэй ээж мөнгөн тэтгэмжид 305 иргэнд 14665,1 мянган төгрөгийг олгож, хүний эрхийн бигийг 40 өрхийн 238 иргэнд олгосон.

Тайлант сард шинэ төрсөн 6, шинээр гэр бүл болсон 1, эцэг тогтоолтын бүртгэл 4, үрчлүүлсэн нас барсан 3, нэр өөрчилсөн 3, иргэний үнэмлэх дахин 6, сунгалт 7, шилжин ирсэн 12, шилжин явсан 14, иргэний бүртгэлийг хийж, мэдээллийн санд оруулан баталгаажуулсан. Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ 4, газрын гэрчилгээ 23 иргэнд олголоо.

### **Жавхлант сүм:**

Сумын төрийн албан хаагчдын зөвлөгөөнийг зохион байгуулж 2018 оны зорилтоо тодорхойлж төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчидтай ашиг сонирхолын гэрээ, эд хөрөнгийн хариуцлагын гэрээ байгууллаа.

Сэлэнгэ аймгийн Миний Монгол телевизээс зохион байгуулсан “Бахархах түүхтэй Жавхлантчууд” нэвтрүүлэг, мөн Миний Монгол телевиз, Молор телевиз “Жавхлант хүлэг” морин спорт уяачдын холбоотой хамтран зохион байгуулсан “Амар байна” уу нэвтрүүлэгт оролцож сар шинийн мэндчилгээ дэвшүүллээ.

Монгол Улсын ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд заасны дагуу сумын Засаг даргын захирамжаар суманд үйл ажиллагаа явуулдаг 44 аж ахуйн нэгж байгууллага 228 ахмадуудад сар шинийн хүндэтгэл үзүүллээ. Мөн 70-с дээш 43 ахмад настанд сумын Засаг дарга, 85-аас дээш 3 ахмад настанд аймгийн Засаг дарга хүндэтгэл үзүүллээ.

Сар шинийн босгон дээр тус сумаас монголын үндэсний радио телевиз, Хүнс хөдөө аж ахуйн яамнаас жил бүр уламжлал болгон тодруулдаг “Алтан төл”- ийн эзнээр Бумбат 1-р багийн малчин Ц. Бат-Эрдэнэ тодорлоо.

Сумын Засаг даргаар ахлуусан ажлын хэсэг сумын хөдөөгийн малчин өрхөөр, төр төсвийн байгууллагын албан хаагчид 1-р улиралын айл өрхөөр ажиллах удирдамжийн дагуу Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2017 оны хэрэгжилт, биелэлтийг харуулсан "Жавхлантын хөгжил"



сэтгүүл, Жавхлантын мэдээ сонин гарын авлага тараах материал тараан иргэдийн санал хүсэлтийг сонсон ажиллалаа.

“Хуулиа мөрдье-21” сарын аяныг сумын хэмжээнд төлөвлөгөө, удирдамж дагуу бүх төр төсвийн байгууллагууд, аж ахуйн нэгжүүдийн дунд зохион байгуулж Засаг даргаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж “Архины эсрэг хамтдаа” сэдэвт сургалтыг зохион байгуулж архины эсрэг хэмтдаа аянд нэгдэж архины тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж дэлгүүрүүдэд хяналт шалгалт хийж гарсан зөрчлийг даруй арилгах талаар заавар зөвлөмж өгч ажиллалаа. Мөн аяны хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд “Дэвжээ” тэмцээн зохион байгууллаа.

Эрүүл агаар эм мөсний баярыг сумын төр төсвийн байгууллагууд, ахмадын хороо, Болд төмөр Ерөө голын цагаан хаалга өртөөний хамт олонтой хамтран зохион байгуулж авхаалж самбаа сорьсон тэмцээн, хээрийн цай амттай зэрэг тэмцээн уралдаануудыг зохион байгууллаа.

Тийн унжлагат шар нохой жилийн сар шинийн баярыг тохиолдуулан үндэсний бөхийн барилдаан, шагайн харваан тэмцээнийг зохион байгууллаа.

Тус сард иргэний 25 бүртгэл хийгдсэнээс төрөлт-2, нас баралт-0, гэрлэлт-1, иргэний үнэмлэхний бүртгэл-7, шилжин ирсэн-4, шилжин явсан-5 бүртгэгдлээ.

Аймгийн ХХҮГазраас харъяалалгүй 10 ахмад настанд сар шинийн баяраар хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардууллаа. Алдарт эхийн 1-р одонтой 64 эх, 2-р одонтой 132 эх нийт 196 эхэд одонгийн мөнгө олгогдлоо.

Нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалын сангаас 2-р сард өндөр настан 307 тэтгэвэр авагчид 90.628 мянган мөгрөг тахир дутуу 91 тэтгэвэр авагчид 19,368,132 мянган төгрөгийн тэтгэвэр тэжээгчээ алдсан 15 тэтгэвэр авагчид 3,941 төгрөгийн тэтгэвэр нийт 307 тэтгэвэр авагчид 90.628 төгрөгийн тэтгэврийг олгосон Ажилгүйдлийн даатгалын сангаас 1 даатгуулагчид 118860 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон Тэтгэмжийн даатгалын сангаас 2 даатгуулагчид 861252 мянган төгрөгийн жирэмсэн амаржсаны тэтгэмж 2 даатгуулагчид 341863 мянган төгрөгийн хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж олгов.

Сумын эрүүл мэндийн төв нь тайлант сард нийт 205 үзлэг бөөрөө үйл урьдчилан нүдэвхтэй 54, амбулаторын үзлэг- 69, идэвхитэй буй арьс -12, гэрийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж зөвлөгөө өгч ажиллалаа. Мөн Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 30 охидыг эрүүл мэндийн үзлэгт хамруулан зөвлөгөө өглөө.

26-р цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтаар үндсэн бүлгээр 869 хүүхэд, явуулын бүлгээр 75 хүүхэд, нийт 914 хүүхдийг эхний 15 хоногийн байдлаар хамруулан сургаад байна. Хүүхдүүдийн дунд “Дээлтэй Монгол” нэг өдрийг зохион байгуулж багш ажилчид хүүхдүүд идэвхитэй хамрагдлаа.

Аймгийн төвд зохион байгуулагдсан “Сэлэнгэд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдаанд 5 иргэн сүү цагаан идээ, шүрэн эдлэл, эсгий урлал, гутал хүнсний ногоо даршилсан бүтээгдэхүүнээр оролцлоо.

### **Зүүнбүрэн сүм:**

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Цагдаагийн ерөнхий газраас зохион байгуулсан “Хуулиа мөрдье-21” аяныг орон нутагт зохион байгуулах удирдамжийн дагуу төр, төсвийн 5 байгууллага, архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг 7 аж ахуйн нэгжүүдийг хамруулан зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээнд хяналт тавих нөлөөллийн арга хэмжээг 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр явуулж, Монгол Улсын Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1, 7.2.2, 7.3.1, 7.4 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 117 тоот тогтоолоор батлагдсан “Архидалттай тэмцэх хөтөлбөр”, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.11 дэх заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор яриа

таниулга хийж, худалдаа, үйлчилгээний 4 дэлгүүр, 3 бар, зоогийн газарт аяны талаар мэдээлэл хийн аяны талаар мэдээлэл бүхий зурагт хуудсыг мэдээллийн самбарт байршуулан ажиллалаа. Мөн Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн ахлах ангийн 60 гаруй сурагчдын дунд “Архи, тамхины хор хөнөөлийн талаархи сургалтыг зохион байгуулж анхан шатны мэдлэг олголоо.

“Бахархах түүхтэй Сэлэнгэчүүд” телевизийн нэвтрүүлгийн зураг авалтанд улс, аймаг, сумын аварга малчин, алдарт уяач, нутгийн удирдлагууд оролцон нийт ард иргэддээ сар шинийн мэндийг дэвшүүлэн Зүүнбүрэн сумын түүхэн замнал, амжилт бахархлын талаар яриа өрнүүлэн урлагийн тоглолт үзүүллээ.

Амбулатороор 267 иргэнд үзлэг хийснээс өвчний учир 112, урьдчилан сэргийлэх үзлэгээр 65, диспансерийн хяналтаар 34, гэрийн идэвхтэй эргэлтээр 26, дуудлагаар 31 иргэнд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүлж, 44 иргэнийг хэвтүүлэн эмчилж, ээлжит товлотт вакцинд 1 хүртэлх насны хүүхдүүдийг 100 хувь хамрууллаа.

СӨБ-ын хамралт сургалт энэ сард хүүхэд өдрийн төлөвлөгөөнд 1500 хүүхэд хамруулахаас 1000 хүүхэд хамруулж 66.6 %-тай байна. 24 цагийн ажиллагаатай бүлгийн хүүхэд өдрийн төлөвлөгөөнд 260 хүүхэд хамруулахаас 125 хүүхэд хамруулж биелэлт 48 хувьтай. Сар шинийн баярыг угтан 14 дүгээр цэцэрлэгт хамрагдаж буй хүүхдүүдийн дунд “Дээлтэй Монгол” үйл ажиллагааг зохион байгуулж Бэлтгэл А, Б бүлгийн дунд алаг мэлхий өрөх, ахлах бүлгийн хүүхдүүдийн дунд шагай шүүрэх, бага, дунд бүлгийн бяцхан хүүхдүүдийн дунд морь уралдуулах тэмцээнийг явууллаа.

Сумын Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт тусгагдсан “Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх стратегийн сум болох” зорилтын хэрэгжилтийг хангах зорилгоор Мал маллагааны арга туршлагаараа тэргүүлж улс, аймаг, сумын аваргаар шалгарч байсан тэргүүний малчдыг оролцуулан, малчдын арга туршлагыг сурталчлах “Аварга малчдын уулзалт хэлэлцүүлэг-2018” арга хэмжээг зохион байгуулж 11 малчдыг хамрууллаа. Бэлчир багийн Охь-хөндийн Их-цагааны өвөлжөөнд байрлалтай малчны хотноос гоц халдварт шүлхий өвчний клиник шинж тэмдэг илэрсэн тухай мэдээлэл авч, сумын Засаг даргын А/21 тоот захирамжаар хязгаарлалтын дэглэм тогтоож, улсын мал эмнэлгийн төв лабораторид шинжилгээний дээжийг шинжлүүлэхэд эрүүл болох нь тогтоогдсон. Хязгаарлалтын хугацаанд малчид мал сүргээ, сумын мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн мэргэжилтний хяналтанд байлгаж, мал эмнэлгийн үзлэг, тандалтанд тогтмол хамруулах, орон нутгийн хэмжээнд малын шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах зэрэг арга хэмжээг авч голомтын бүсэд тогтмол эргүүл пост ажиллууллаа.

“Цагаан сар 2018” үзэсгэлэн худалдааг 2018 оны 02 дугаар сарын 02-нд зохион байгуулж 50 гаруй иргэд сүү, сүүн бүтээгдэхүүн, мах махан бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүн, гар урлал бэлэг дурсгал, үндэсний хувцас гэсэн төрлөөр оролцож 3200,000 гаруй төгрөгийн борлуулалт хийснээс гадна аймгийн төв Сүхбаатар суманд зохион байгуулагдсан “Сэлэнгэд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдаанд 1 аж ахуйн нэгж, 11 иргэн сүү сүүн бүтээгдэхүүн, мах махан бүтээгдэхүүн, даршилсан ногоо, гар урлал бэлэг дурсгал, үндэсний хувцас, монгол гутал гөлөм зэрэг төрлөөр оролцож 9500,000 төгрөгийн борлуулалт хийлээ.

### **Мандал сум:**

Мандал сумын удирдах ажилтны зөвлөгөөн боллоо. Зөвлөгөөнөөр 2017 онд байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэхэд 31 байгууллага А, В буюу сайн үнэлэгдэж 2018 онд хамтран ажиллах гэрээгээ шинэчлэн байгууллаа.

Сар шинийн баярт зориулсан хүчит 64 бөхийн барилдаан боллоо. Хүчит бөхийн барилдаанд Монгол улсын заан Б.Батмөнх, Улсын харцага Н.Бат-Өлзий, Улсын начин Б.Бат-Эрдэнэ, Улсын начин Ч.Баянмөнх тэргүүтэй улсын цолтой арваад бөх, аймгийн цолтой 10 гаруй бөхчүүд зодоглов. Улсын заан Б.Батмөнх, Улсын харцага Н.Бат-Өлзий, Улсын начин Б.Бат-Эрдэнэ, Улсын начин Ч.Баянмөнх нарын бөхчүүд шөвгөрч,

үзүүр түрүүнд Улсын заан Б.Батмөнх, Улсын харцага Н.Бат-Өлзийг уран мэхийг уралдуулан давж түрүүлээ.

“Номын сайн нөхөр” хөтөлбөрийн хүрээнд сумын иргэдийг номонд дуртай болгох, ном унших сэдлийг нь төрүүлэх зорилгоор Мандал ТВ-ын Уран зохиолын цаг нэвтрүүлэгт, Номтой нөхөрлөө клубын 5 гишүүн оролцож ном анх уншсан сэтгэгдэл, ном унших арга, номтой нөхөрлөх тухай сонирхолтой ярилцлага хийлээ.

Сумын харъяалалгүй өндөр настан, 80-аас дээш насны ахмад настнуудад сар шинийн хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж 300 гаруй ахмад настныг хамрууллаа. Өөрийн биеэр ирэх боломжгүй ахмадуудад багийн Засаг даргаар дамжуулан харъяалалгүй өндөр настан-450, 80-84 насны ахмад настан-135, 85-аас дээш насны ахмад настан-72 нийт 657 өндөр настанд хүндэтгэл үзүүлэн, гарын бэлэг гардуулж, сумын Засаг даргын Тамгын газраас өндөр насны тэтгэвэрт гарсан 23 ахмад настныг хүлээн авч хүндэтгэл үзүүлээ.

Сумын малчдын зөвлөгөөнийг зохион байгуулж, зөвлөгөөнд 9 багийн 389 малчин мал бүхий иргэдийн төлөөлөл оролцож цаг үеийн мэдээлэл болон мал аж ахуйд цаашид авч хэрэгжүүлэх ажил арга хэмжээний талаархи мэдээлэл, мал эмнэлэгийн шинэ гарсан хуул, малчны үүрэг оролцооны талаар мэдээлэл өглөө. Мөн 2017 онд үндэсний боловсруулах үйлдвэрт арьс шир тушаасан 401 иргэний материалыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлээ.

Сумын Засаг даргын шийдвэрээр газар эзэмших эрхээ бусдад шилжүүлэх 47 иргэний 412,5 га, газраа баталгаажуулах 1 аж ахуйн нэгжийн 0,27 га, 3 иргэний 1,1 га газрыг шийдвэрлээд шийдвэрлэж, багийн ИНХурал болон Багийн Засаг даргын 2017 оны тайлангийн хуралд “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Газрын дуудлага худалдаа, Давуу эрхийн газар, Хаягжилтийн тухай хууль”-аар мэдээлэл хийж, асуултанд хариулт өглөө.

Аймгийн ИТХ-ын 2018 оны 02 сарын 01-ны өдрийн 47 тоот тогтоолоор Мандал суманд хэрэглээ- 29610 м3, түлээ- 24240 м3 мод бэлтгэлийн хуваарь олгосон.

### **Орхон сум:**

Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймаг, сумын эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан заалт зорилтуудын хүрээнд сумын Засаг даргын 2018 оны 01 тоот захирамжаар төрийн үйлчилгээ үзүүлж буй төрийн албан хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх хууль эрх зүйн цаг болон иргэдэд төр төсвийн байгууллагуудаас цаг үеийн мэдээ мэдээлэл хүргэх “Тайлан мэдээлэл санал шийдэл” нэрэмжит өдрийн хуваарийг гарган мэдээ мэдээллийн төлөвлөлт хийж батлууллаа.

Сумын “Малчдын зөвлөгөөн-2018” арга хэмжээг 2-р сарын 01-ний өдөр сумын соёлын төвд, сар шинийн баярыг угтан зохион байгуулагдсан баялаг бүтээгчдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах борлуулалтыг нь дэмжих зорилгоор “Орхонд үйлдвэрлэв-2018” үзэсгэлэн худалдааг ЕБС-ийн спорт зааланд тус тус зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдаанд 19 иргэн давхардсан тоогоор 54 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож ийт 2425000 төгрөгийн худалдан авалт, борлуулалт хийснээс хамгийн их эрэлт хэрэгцээтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэгчээр Ш.Оюун-Эрдэнэ /сүүн хурууд, сүүн ааруул/, хамгийн олон нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчээр Л.Отгончимэг /хачиртай утсан загас, 8 төрлийн хоол/ нар шалгарч батламж гардан авлаа. Мөн аймгийн төвд зохион байгуулагдсан “Сэлэнгэд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдаанд 1-р багийн 2 иргэн сүү цагаан идээ, утсан загас, даршилсан ногоогоор оролцож 1,0 сая төгрөгийн борлуулалт хийсэн.

Сар шинийн баярыг тохиолдуулан 2017 оны онцлох ажил үйлчилгээ, 2018 онд хийгдэх шинэлэг ажил үйлчилгээ болон орон нутгийн мэдээ мэдээллийг тусгасан “ОРХОНЫ МЭДЭЭ” сэтгүүлийг эрхлэн гаргаж 300 өрхөд хүргэж иргэдийг мэдээ мэдээллээр хангаж ажиллалаа.

“Өвөл хаврыг өнтэй давъя” аяны хүрээнд малчдад 20 тн өвсийг үнэ төлбөргүй тарааж 20 тн хивэгийг зах зээлийн үнээс хямдаар 1 шуудай хивэгийг 9000 мянган төгрөгөөр малчдад нийлүүллээ.

Тайлант хугацаанд өөр аймаг дүүргээс шилжиж ирсэн болон хуучин ажиллаж байсан байгууллага нь дампуурсан татан буугдсанаас болж харъяалалгүй болсон 20 ахмад настанд сар шинийн баяраар гарын бэлэг өгсөн. Мөн хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 15 өрхийн 92 иргэнд 1,2-р сарын хүнсний эрхийн бичгийг олгож нийт 1,928,000 төгрөгийн хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэн тус тус ажилласан. 2018 оны 02 дугаар сарын байдлаар нийт 259 иргэнд 17,776,490 төгрөгийг тус тус олгосон.

2018 оны 2 сарын 9-нд сумын ИТХ-д сум хөгжүүлэх сангийн 2017 оны тайлан тавьж, сум хөгжүүлэх сангийн бодлого чиглэлийг батлуулан ажилласан.1. Төмс хүнсний ногоо тариалах 2. Сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 3.Зоорины аж ахуй эрхлэх, 4. Хүлэмжийн аж ахуй эрхлэх 5.Зоогийн газар кафе. Зээлийн дээд хэмжээг 20 сая төгрөг хүртэл зээлийн эргэн төлөлтийн хугацааг 36 сар хүртэл тодорхойлсон.

2018 онд тариалахаар нөөцөлсөн үрийн судалгааг дутагдаж байгаа нийт үрийн судалгааг гаргаж аймгийн МХГ болон ХХААГ-т хүргүүлэн ажилласан.

Орхон сумын 12-р цэцэрлэг нь 2018 оны 02-р сард сургалт хүмүүжлийн үйл ажиллагаагаар нийт 1145 хүүхдийг хамруулж багш, ажилчид ажлын цагийг баримтлан үр бүтээлтэй ашиглаж ажиллалаа. Бүлгийн багш, туслах багш нар ажлын байран дахь ур чадвар, бүтээлч арга барилаа нэмэгдүүлэх зорилгоор хуваарийн дагуу нээлттэй хөгжүүлэх үйл ажиллагааг зохион явууллаа. Бүлгийн багш нар сургалтын хөтөлбөрийн хуваарийн дагуу “Цагаан сар” сэдвийн хүрээнд дунд бүлэгт, туслах багш нар өөрсдийн бэлтгэсэн сэдвийн хүрээнд бэлтгэл бүлэгт хөгжүүлэх үйл ажиллагааг зааж, бэлтгэл бүлгийн хүүхдүүдийн дунд асуулт, хариулт, танин мэдэхүйн “АХА” тэмцээнийг явуулж, ардын уламжлалт өв соёлыг танин мэдүүлэх зорилгоор ёс заншлийн өргөөг хийж хүүхдүүдийг ардын уламжлалт тоглоом наадгай, уламжлалт соёлд сурган ажиллаж байна.

Сумын эрүүл мэндийн төвөөс тайлант сард “Амьлуулах суурь тусламж, “Түлэгдэлтийн үед үзүүлэх анхны тусламж үйлчилгээ, “Осол гэмтэл” сургалтуудыг ЕБС болон цэцэрлэгийн багш ажилчдад зохион явуулсан. Нийт сургалтанд 53 хүн хамруулж, ард иргэдийн идэвхтэй хөдөлгөөн, бие бялдрыг чийрэгжүүлэх зорилгоор “Хөдөлгөөн эрүүл мэнд” цасны баярын арга хэмжээг зохион байгуулж, 58 хүн хамрагдсан. Мөн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг тухай бүрт нь үзүүлж, нийт 443 эмчийн үзлэг хийж, 26 үеэс үеийг үргэлжлэн.

### **Орхонтуул сум:**

Тайлант сард тус сумын Засаг даргын Тамгын газар нь иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цаг хугацаанд нь хурдан шуурхай үзүүлж ажилласны дээр сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2017 хэрэгжилт, үр дүнг иргэдэд тайлагнах ажлыг зохион байгууллаа.

Сумын хэмжээнд өвөлжилт хүндэрч байгаа тул зам даваа хаагдсан газруудад өвөлжиж байгаа малчдын хотонд хүрч, амьдрал ахуйтай газар дээр танилцаж тэдний санал хүсэлтийг сонсох малчдын сэтгэл санааг дэмжих зорилгоор сумын ИТХ-н дарга, Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын даргаар ахлуулсан 4 ажлын хэсэг ажиллаж, аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газраас ирүүлсэн тусламжийн зүйлсийг малчдад гардуулан өгсөн байна. Мөн аймгийн Засаг дарга сумын өвөлжилтийн нөхцөл байдалтай танилцаж, малчид иргэдтэй уулзалт хийж, аймгийн нөөцөөс өвс, тэжээлийн тусламж үзүүллээ.

Сар шинийн баярыг угтан уламжлал ёсоор аймаг, сумын Сайн малчин, Алдарт уяачдын материалыг бүрдүүлэн дээд шатны байгууллагуудад хүргүүлэхээс гадна сумын Сайн малчин, Алдарт уяач тодруулан шагнаж урамшууллаа. Сумын “Сайн малчин”-аар Баянцогт 2-р багийн малчин Л.Бат-Отгон, Хонгор-Овоо 3-р багийн малчин Н.Содномпил, сумын “Алдарт уяач”-аар Шар-Ус 1-р баг, Рашаант тосгоны

иргэн Н.Мягмаржав нар нь сумын Шагналын болзол журмын хангасан тул энгэрийн тэмдэг, өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнаж урамшууллаа. Сумын сайн малчин, алдарт уяачийн шагналд зарцуулах 300,000 төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулсан байна.

Нийгмийн халамжийн сангийн 01-02-р сарын халамжийн тэтгэвэрийг 41 хүнд 11957740 төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 23 хүнд 3099040 төгрөг, жирэмсэн амаржсаны тэтгэмжийг 8 эхэд 556270 төгрөг, 0-3 насны хүүхэдтэй 74 эхэд 8319470 төгрөг, 0-18 насны хүүхэдтэй 2 эхэд 480000, Алдарт эхийн 1-р одонтой 47 эхэд 9400000, 2-р одонтой 127 эхэд 12700000 төгрөг, Насны хишиг 58 иргэнд 6730000 төгрөгийг тус тус олгосон байна. Алдар цолтой 5 ахмад настанд тусламж 1600000 төгрөг олголоо. Жирэмсэн эхийн тэтгэмжид шинээр 10 эх, 0-18 насны олон хүүхэдтэй өрх толгойлсон 3 эх, Насны хишгийн тэтгэмжид шинээр 4 иргэнийг тус тус шинээр хамруулж тэтгэвэр, тэтгэмжийг олголоо. Насны хишиг авах 58 иргэний 2018 оны бичиг баримтын баяжилт хийж, программд шивж, тэтгэмжийг олгосон байна. Алдарт эхийн одонтой 174 эхийн хувийн хэргийн баяжилт хийж, программд шивж одонгийн мөнгийг олгож дуусгасан байна.

2017 оны эцэст сумын дүнгээр 184757 мал тоологдсоноос тэмээ-403, адуу-13068, үхэр-16977, хонь-88264, ямаа-66045 тоологдсон.

Сумын мал хаваржилтын ажил нь 02-р сарын 23-ны байдлаар оны эхний малын 0,7% буюу 1367 толгой мал хорогдсоноос адуу 42 үхэр 280 хонь 529 ямаа 516 хорогдсон. 2018 онд 85975 хээлтэгч төллөхөөс мал төллөлт төл бойжилт одоогийн байдлаар 1287 толгой мал төллөж гарсан төлийн 99,5% бойжиж байна. 2018 онд 85975 хээлтэгч төллөнө. Цас зудын улмаас малын тарга хүч муудах, хэвтэрт орох, хээл хаях зэрэг сөрөг үр дагвар гарч байгааг харгалзан малчид иргэдэд зөвлөмж өгөх урьдчилан сэргийлэх талаар анхааран ажиллаж байна.

2018 оны өвөл цагаан зудын байдалтай байгаа тул аймгийн нөөцөөс олгосон 2000 кг минралны тэжээлийг Баруунхараагаас авчирж малчдад тараалаа. Түүнчлэн улсын нөөцөөс 4000 боодол өвс, УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбатаас 2000 боодол өвс, мөн 8000 шуудай тэжээлийг Дархан уул аймгийн Хонгор сумаас татаж малчид иргэдэд хуваарилан олгоод байна.

### **Сайхан сум:**

Суманд үйл ажиллагаа явуулж буй согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг 35 аж ахуйн нэгж, цэгүүдэд “ХУУЛИА МӨРДЬЕ-21” аяны мэдээ мэдээлэл хүргэж, тараах материалыг байршуулан ажилласан байна. Мөн орон нутгийн “Эрдэнэ ТВ”-ээр иргэдэд согтууруулах ундааны хор уршиг болон Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн талаар мэдээ мэдээлэл, шторк цацан ажиллалаа. Цахим хуудас болох Facebook-д шторк мэдээ мэдээлэл, уриалга болон санамжыг сумын page хаягт байршуулж бусад хөтөлийн 7 group-д Цагаагийн хэлтэсийн page хуудас, Хөтөл цагдаа group-дэд share хийж мэдээлэл байршуулж ажиллалаа. Сумын Засаг даргын Тамгын газар, Сайхан сум дахь Цагдаагийн хэлтэс, Сайхан сум дахь сум дунд Прокурор, Сайхан сум дахь сум дундын Шүүхтэй хамтран 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Хөтөл ЕБС-ийн 9-12 ангийн сурагчдад Хүүхдийн эрх ба төлөвшил хүмүүжил, Мансууруулах болон хар тамхины хор хөнөөл, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Тамхины хяналтын тухай хуулиар хэлэлцүүлэг зохион байгуулан ажиллалаа. Энэхүү хэлэлцүүлгийн хүрээнд 360 гаруй сурагч хамрагдсан байна.

Сум, багийн түвшинд ажиллаж буй хамтарсан багийн гишүүдийн хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай үндсэн ойлголт өгөх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах сургалт 2-р сарын 08,09-ны өдрүүдэд Сайхан суманд зохион байгуулагдлаа. Сургалтанд Орхон, Орхонтуул, Сант, Баруунбүрэн, Мандал, Баянгол, Хушаат сум, Номгон тосгоны хамтарсан багийн гишүүд хамрагдлаа. Сургалтыг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, ДЗОУБ-ын

ЗХОНХХөтөлбөр, Сайхан сумын Засаг даргын Тамгын газар хамтран зохион байгуулсан.

Сайхан сумын өвөлжилт хүндэрч байгаатай холбогдуулан Хүдэр сумаас 1000 боодол өвсийг татан авч малчин болон мал бүхий иргэддээ тарааж, цаг агаарын мэдээ мэдээллийг 50 гаруй өрхөд утсаар мэдээлсэн. Мөн Номгон тосгоны малтай болон мал бүхий 56 өрхийн 280 үхэрт зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор гэрэлтдэг хүзүүвчтэй болголоо.

2018 оны 02-р сарын сумын татварын орлогын төлөвлөгөө өссөн дүнгээр 46,145.5 мянган төгрөг, гүйцэтгэл 42,233.22 мянган төгрөг буюу 91.52 хувийн биелэлттэй байна. Аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг өссөн дүнгээр 78,866.6 мянган төгрөг буюу 100 хувь олгогдсон. Тусгай зориулалтын шилжүүлэгийн 11 байгууллагуудад нийт 647,263.70 мянган төгрөгний санхүүжилт 100 хувь олгогдлоо. Орон нутгийн 4 байгууллагад нийтдээ 161,579.1 мянган төгрөгний санхүүжилт 100 хувь олгогдсон.

Сар шинийн баярт зориулан 2018 оны 02 дугаар сарын 05-06-ны өдрүүдэд аймгийн төвд болсон “Сэлэнгэд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдаанд цагаан идээ-1, гар урлал-1, оёдол-3, Сайханы гутал-1, Хөтөл хиама-1 нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй амжилттай оролцлоо.

Ерөнхий боловсролын сургуулийн багш бүр сургалтын хөтөлбөр боловсруулан, баталгаажуулан ажиллаж байна. Мөнх ахмад багш нар залуу багш нарын хичээлд сууж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байна. 2017-2018 оны хичээлийн жилийн 2-р улирлын хичээл сургалт, сургууль бүрт хичээлийн хуваарийн дагуу явуулж байгаа бөгөөд сар шинийн баярыг тохиолдуулан сурагчдын дунд үндэсний өв уламжлалыг сэргээн хөгжүүлэх чиглэлээр жил бүр уламжлал болгон явагддаг “Дээлтэй монгол” өдөрлөгийг зохион байгууллаа. Мөн сургуулийн Үндэсний бөхийн аврага шалгаруулах тэмцээн, эцэг эхчүүдийн дунд уламжлал болгон зохион явуулдаг “Эцэг эхийн IQ” олимпиад, “Алтан хонх” уралдаанууд амжилттай зохион байгуулагдлаа.

Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэн өдөр тутмын үйл ажиллагаагаар хүүхдэд олгогдох чадваруудыг эзэмшүүлэн хөгжүүлэх үйл ажиллагааг тогтмолжуулан ажиллаж байна.Сар шинийн баяр болохтой холбогдуулан бага насны хүүхдэд ардын ёс заншлаас суралцуулах тэдний танин мэдэхүйн төсөөллийг нэмэгдүүлэх зорилгоор хүүхдэд ашиглах сургалтын хэрэглэгдэхүүн материалуудыг бэлтгэн хөгжүүлэх үйл ажиллагаандаа ашигласан байна.

Цэцэрлэг бүр уламжлал болгон явагддаг “Дөрвөн бэрх”, “Дээлтэй Монгол” зэрэг өдөрлөгийг бүлэг бүрийн дунд зохион байгуулан бүлгийн хүүхдүүд хоорондоо оньсого таалцан, алаг мэлхий өрөн, хадаг барих ёс, золгох ёс, хөөрөг зөрүүлэх ёс, цагаан сарын бэлэгдэл, цагаан сараар цээрлэх ёс, дайралцаа үг, ерөөл магтаал зэргээс суралцсан үйл ажиллагааг зохион байгуулав.

### **Сүхбаатар сум:**

Монголын уламжлалт сар шинийн баярыг тохиолдуулан байгууллагын харъяалалгүй 800 ахмад настанд хүндэтгэл үзүүлэн аймаг, сумын Засаг даргын гарын бэлгийг гардууллаа.

Мөн баярын өдрүүдэд болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх үүднээс сумын хариуцлагатай жижүүрийг томилон ажиллуулж, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шаардлагатай эм эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлэн ажиллах талаар чиглэл өгсөн. Мөн гамшиг осол, гал түймрийн аюулд өртөх эрсдэл бүхий айл өрхийн судалгааг гарган аймгийн Онцгой байдлын газраас сэрэмжлүүлэг материал тараан зөвлөмж өгч ажиллалаа.

Цас ихээр орж зам хальтиргаа гулгаа ихээр үүсч автомашины осол, хүүхэд хөгшид гэмтэх магадлал ихэссэнтэй холбогдуулан нийтийн эзэмшлийн зам талбайн цасыг цэвэрлэх ажлыг зохион байгууллаа.

2018 онд дуурлаас гаргах 80 өрхийн судалгааг шинэчилж, сумын орон гэргүй иргэдийг судалгааг гаргаж, 1-р багийн 1 иргэнд 1800,0 мянган төгрөгийн гэрийн иж бүрэн хэрэгсэл олгож дэмжлэг үзүүлээ.

Сүхбаатар сумын иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг түлшний модоор хангах гэрээг Түшиг Ерөө, Хүдэр сумдтай байгуулж, одоогийн байдлаар Түшиг сумын Хар горхи гэх газарт 466 ширхэг мод бэлтгэх эрхийн бичгийг олгож, 1864 м3 түлшний модыг ард иргэдэд олгоод байна.

Монгол ардын хувьсгалын журамт цэргийн жанжин, Цэргийн яамны сайд Д.Сүхбаатарын мэндэлсний 125 жилийн ойг тохиолдуулан сумын ИТХ, Засаг даргын тамгын газрын албан хаагчдын дунд спортын нөхөрсөг тэмцээнийг 3 төрлөөр зохион байгууллаа.

### **Хушаат сум:**

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2017 оны "Улсын аварга тариаланч хамт олон"-оор шалгарсан тус сумын "Элит үр" ХХК, "Цэгээн хуст" ХХК-иуд, "Улсын аварга тариаланч"-аар шалгарсан "Өгөөж Мандал уул" ХХК-ийн тракторчин Н.Жаргалбат нарын шагналыг УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат, аймгийн Засаг дарга Ш.Оргил, аймгийн ХХААГ-ын дарга Б.Мөнхтөр нар гардуулан өглөө.

2017 оны "Аймгийн аварга малчин"-аар тус сумын малчин Алтансүх, П.Норолхоо, "Аймгийн аварга фермер"-ээр малчин Б.Эрдэнэ, Сугар, "Аймгийн аварга тариаланч"-аар тариаланч Б.Ганбат нар тус тус шалгарлаа.

Сар шинийн баярыг тохиолдуулан үндэсний бөхийн барилдааныг зохион байгуулж, аймгийн начин Б.Хүдэрбаатар түрүүлж аймгийн начин Х.Чинбат үзүүрлэлээ. Мөн уламжлал ёсоор суманд үйл ажиллагаа явуулж байгаа төр төсвийн байгууллага, ААН-үүдэд ахмадуудаа хуваарилан өгч гарын бэлгийг гардуулан хүндэтгэл үзүүлсэн ба "Өгөөж мандал уул" ХХК сумын 70-аас дээш насны 74 ахмад настанд 3,7 сая гаруй төгрөгийн сар шинийн тавгийн идээг гарын бэлэг болгон өгч хүндэтгэл үзүүллээ.

Улсын бүртгэлийн үйлчилгээгээр төрөлт 2, эцэг тогтоолт 2, шилжин явсны 3, шилжин ирсний 3, гэрлэлтийн 1, нас барсны 1, цахим үнэмлэх дахин авах 1, биеийн давхцахгүй өгөгдлийн 3, үл хөдлөх хөрөнгийн эрхийн 4, газар өмчлөх эрхийн 6, иргэний үнэмлэх олголтын 1 нийт 27 бүртгэл хийж 5 гэрчилгээ бичин олгосон. Орон нутгийн дансанд 16200, УБСГ-ын дансанд 68000 төгрөгийн орлого оруулсан байна.

ЕБС-ийн сурагчдыг оюуны спортоор хичээллэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор сургуулийн 1 өрөөг тохижуулан шатрын дугуйлан нээж шатрын спортын мастер С.Цэдэн-иш хичээллүүлж 2 ээлжээр 10 сурагч хамрагдаад байна.

"Боловсрол" хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй "Утгын чимэг уран сэтгэмж" хөтөлбөрийн дагуу "Хамтдаа уншья" аяныг зохион байгуулж 1-2-р ангийн сурагчид "Аавтайгаа, ахтайгаа уншья" аян, 3-р ангийн сурагчид "Ээжтэйгээ эгчтэйгээ уншья" аянд, 4-5-р ангийн сурагчид "Багштайгаа, найзтайгаа уншья" аяныг өрнүүлж эцэг эхчүүд, сурагчид идэвхитэй хамрагдлаа.

Цэцэрлэгийн хамран сургалтаар бэлтгэл бүлэг 149 хүүхэд 33%, ахлах бүлэг 206 хүүхэд 46 %, дундб үлэг 280 хүүхэд 62%, бага бүлэг 197 хүүхэд 44%-тай байна. "Амны хөндийн эрүүл мэнд" аяны хүрээнд цэцэрлэгийн 2-5 хүртэлх насны нийт 60 хүүхдэд үзлэг, эмчилгээнд хамруулсан.

ЖДҮ –ийн борлуулалтыг дэмжих, бүтээгдэхүүнийг сурталчлах, сумын иргэдийг сүү, цагаан идээ, орон нутгийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнээр хангах зорилгоор "Хушаатад үйлдвэрлэв", "Цагаан сар-2018" үзэсгэлэн худалдааг уламжлал болгон 4 дэхь жилдээ зохион байгуулж, 15 иргэн өөрсдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээрээ оролцож 2595000 төгрөгийн борлуулалт хийгдлээ

Сумын хэмжээнд энэ сард 45 мал зүй бусаар хорогдсон ба үүнээс адуу 3 үхэр 6, хонь 16, ямаа 20 толгой хорогджээ. Мал төллөлтийн мэдээгээр 65 төл гарснаас тугал 19, хурга 25, ишиг 21 толгойгоор нэмэгдэн эсэн мэнд бойжиж байна.

## Хүдэр сум:

Тайлант сард сумын Засаг даргын зөвлөлийн хурал 3 удаа хуралдаж, сумын төвийн бетонон зам цэвэрлэх, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль 5 сард дуусгавар болохтой холбогдуулан иргэдэд газар өмчлөх асуудлыг шийдвэрлэх ажлын хэсэг байгуулах, ИТХ-д өргөн мэдүүлэх материалыг бэлтгэх тухай, Цагаан сар 2018 үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, сумын ажил мэргэжлийн 9 алдартан тодруулах тухай болон ахмад настангуудад хүндэтгэл үзүүлэх зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Суманд “Цагаан сар-2018” үзэсгэлэн худалдаа зохион байгуулж 95 иргэн, сүү, цагаан идээ, даршилсан ногоо, мах, махан бүтээгдэхүүн, монгол дээл зэрэг үзэсгэлэнг гаргаж 70 иргэн хамрагдаж 14 сая төгрөгийн худалдаа хийгдсэн байна. Мөн Сэлэнгэ аймагт зохион байгуулагдсан үзэсгэлэн худалдаанд сумын 3 иргэн даршилсан ногоо, сүү, цагаан идээгээр оролцож 4,0 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Жил бүр уламжлал болсон сумын ажил мэргэжлийн аваргууд тодруулж, шагналыг сар шинийн өмнө гардуулан өгч, суманд үйл ажиллагаа явуулдаг 15 аж ахуйн нэгж, төр төсвийн 5 байгууллага нийт 210 ахмад настанд хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг олголоо.

Сумын удирдлагууд хөдөөгийн 80 гаруй өрхийн өвөлжилтийн байдалтай газар дээр нь танилцаж, цаг үеийн мэдээлэл хүргэлээ.

Монгол улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа “Хуулиа мөрдье 21” арга хэмжээний хүрээнд Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль зэргийг сурталчлан иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор хэсэгчилсэн арга хэмжээний төлөвлөгөөг гарган ажиллаж, төрийн алба хаагч нарын дунд болон ЕБС-н ахлан анги буюу 8-12 р ангийн сурагчдын дунд Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, шинэчлэгдэн батлагдсан Зөрчлийн тухай хуулиудын тодорхой заалтуудаар сургалтыг зохион байгуулан архины хор хөнөөлийн талаарх яриаг сумын нийгмийн ажилтан, ЕБС-н нийгмийн ажилтан нарын хамтаар нийт 52 төрийн албан хаагч, 96 сурагчдыг хамруулан сургалтыг зохион байгуулж нийт сурагчдын дунд танин мэдэхүй болон сургалтаар заасан хуулиудаар бэлтгэсэн асуулттай “АХА” тэмцээнийг зохион байгуулж тэргүүлсэн сурагчдыг шагнаж урамшууллаа. Аяны хүрээнд сумын цагдаагийн хэсэгтэй хамтран хяналт шалгалтыг суманд үйл ажиллагаа явуулдаг 16 дэлгүүр, архины тусгай зөвшөөрөлтэй 7 дэлгүүр, 4 гуанзанд хийлээ. Уг хяналт шалгалтаар зөвшөөрөлгүй тахим борлуулж байсан 1 дэлгүүрээс 48 ширхэг 3 төрлийн тамхийг хураан авч цагдаагийн хэсэгт хүлээлгэн өгсөн.

ЕБС-иас “Багшийн EQ сэтгэлгээг жолоодох чадвар” сургалтыг нийт 48 багш ажилчдыг хамруулан зохион байгуулж, “Ном бидний нөхөр” ном эмчлэх аян 1-12-р ангийн 536 сурагчдын дунд зохион байгуулж нийт 2318 номыг засаж сайжрууллаа.

2018 оны эхэнд тойргийн 251 хүүхдээс СӨБ-д 231 хүүхэд хамрагдан хамран сургалт 92 хувь хамрагдаж ахисан үзүүлэлттэй байна. Сургалтын хөтөлбөрт 2 сарыг “Уламжлалт зан заншлийг өвлөхгүй” сэдвийн хүрээнд зохион байгуулж тоглоонгоо хөгжих арга зүйд суралцан хэрэгжүүлсэн. Бүлгүүдийн Монгол бахархалын буланг баяжуулан уламжлалт ёс, зочныг угтах, үдэх ёс, монгол ардын тоглоом наадгайтай танилцуулж монгол зан үйлээс суралцуулан ажиллаж байна. Мөн Бяцхан даамчин хөдөлгөөн өрнүүлж 4 бүлгийн 92 хүүхэд даамны дугуйланд хичээллэж байна.

Сумын хүн амд эмнэлэгийн тусламж үйлчилгээг стандартын дагуу чанартай үзүүлж, тайланд сард эмнэлэгт хэвтсэн 27, эмчлэгдэж гарсан 21, ор хоног 184, бүгд дуудлага 184, амбулаторийн үзлэг 212, урьдчилан сэргийлэх 56, хяналтанд байгаа жирэмсэн эх 38 байна. Шинээр төрсөн 2 нярайг эхийн хамт гэрээр эргэлт хийж асаргаа сувилгааны талаар зөвлөгөө өгч ажиллаа. Жирэмсэн эхчүүдийн дунд жирэмсэний аюултай шинж, эрүүл ахуй, хоололт сэдвээр сургалт зохион байгууллаа. 0-15 настай 33 хүүхдийг бүртгэн авч дархлаажуулалтанд бүрэн хамруулж түр оршин суух 3 хүүхдийг нэмж хамруулан ажилласан.



Зорилтод бүлгийн өрхөд хүнсний эрхийн бичгээр үйлчлэх дэлгүүрийг сонгон шалгаруулах 3 аж ахуйн нэгж тендерт материалаа ирүүлж “Хүдэр хүслэн” ХХК-ний хүнсний дэлгүүр шалгарч хамтран ажиллах гэрээг байгуулсан. Нийгмийн хамгаалалын тухай хуулийн дагуу шинээр асаргааны тэтгэмжид 1 ахмад настан, асаргааны мөнгөн тэтгэмж сунгуулах 2 ахмад, 2 ХБИргэн өргөдөл өгч нөхцөл байдлын үнэлгээг хийн амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, нийгмийн халамжийн сангаас 511 иргэнд 51,974,240 мянган төгрөгийн тэтгэвэр тэтгэмж олгосон байна.

Тайланд сард төрсний бүртгэлд 5 хүүхэд бүртгүүлж РД олгосноос эрэгтэй 3, эмэгтэй 2 хүүхэд гэрчилгээ авсан. Мөн нөхөн эцэг тогтоолтын бүртгэл 1 хүүхдэд хийгдсэн болно. 16 нас хүрсэн 8 иргэн, 25, 45 насны сунгалт хийлгэсэн 4 иргэн байна. Үүнээс гадна цахим үнэмлэхээ гээгдүүлсэн 4 иргэн үнэмлэхээ захиалж, хэвлэгдэн ирсэн 9 иргэний цахим үнэмлэхийг олгосон байна. Өөр аймаг, сумаас шилжин ирсэн 3, баг хооронд шилжсэн 2, шилжиж явсан 1 иргэн байна.

### **Түшиг сум:**

Арван долдугаар жарны “Тийн унжлагат” хэмээх гал тахиа жилд амжилт бүтээлээрээ бусдыгаа хошуучлан ажилласан иргэн, аж ахуйн нэгжээ тодруулж, Улсын болон аймаг, сумын аваргаар тодорсон аж ахуйн нэгж, иргэдийн шагналыг гардуулан өглөө.

Сар шинийн баярыг тохиолдуулан ахмадуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж, нийт 157 ахмад настанд хүндэтгэл үзүүллээ.

Энэ сарын 23-нд аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн дарга нар сумын иргэдтэй уулзалт хийж, 2018 онд хийгдэх хөрөнгө оруулалт, төсвийн мэдээллийг танилцуулсан.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтын хүрээнд “Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг, сумын эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдүүлэх цогц үзлэг оношлогоо” 2-р сарын 22, 23-нд тус суманд болж, 15-аас дээш насны иргэдийн 68,5 хувь нь хамрагдсан.

Аймгийн төвд зохион байгуулагдсан “Сэлэнгэд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдаанд тус сумын 8 иргэн оролцож, 2,0 сая гаруй төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Малчин өрхийн өвөлжилтийн байдалтай танилцаг ажлыг Бооц, Харгорхи, Хүйтэн чиглэлд ажиллуулж, сумын хөдөө аж ахуйн тасаг, эрүүл мэндийн төв, нүүдлийн номын сан үйлчилгээ үзүүлж, мэдээ мэдээлэл өглөө. Мөн ноосны урамшууллыг сумын хэмжээний 86 малчин өрх 20,3 сая төгрөгийн урамшууллыг авч, урамшуулал олгогдоогүй 7 иргэний дансанд залруулга хийж ажиллалаа.

“Хуулиа мөрдье” арга хэмжээг удирдамж, төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг аж ахуйн нэгжүүдэд мэдэгдэл өгч, ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад видео сургалт хийлээ.

Тайлант сард шинээр төрсөн 3, эцэг тогтоолт 1, иргэний үнэмлэх олголт 3, шинээр захиалсан 5, сунгалт хийлгэсэн 10, иргэний үнэмлэхээ дахин захиалсан 3 иргэнд үйлчилгээ үзүүллээ.

### **Цагааннуур сум:**

“Хуулиа мөрдье-21” сарын аяны зорилго үйл ажиллагааг мэдэлэлийн самбар болон Цагааннуур зар мэдээ болон албан ёсны цахим хуудас, Face book-ээр сурталчилж, согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 7 аж ахуйн нэгжийн 2 бар, 1 кафе, 4 миний маркетийн захирал, менежер нарт архины хор хөнөөлийн талаар гарын авлага, зөвлөгөө мэдээлэл өгч, ЕБС-ийн мэдээллийн самбар, дотуур байрны мэдээллийн самбарт сурталчилгааны материал байршуулсан.

Мөн сумын Засаг даргын Тамгын газрын холбогдох мэргэжилтнүүд архины хор хөнөөлийн тухай, гэр бүлийн хүчирхийллийн тухай, Зөрчлийн тухай, Архидан

согтуурахтай тэмцэх тухай, Нийгмийн даатгалын хуулиар сурталт хийж, 20 гаруй иргэн хамрагдсан.

Аймгийн төвд зохион байгуулагдсан “Цагаан сар-2018” үзэсгэлэн худалдаанд 8 иргэн 6 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож, 2100,0 мянган төгрөгийн борлуулалт хийснээс гадна сар шинийн баярыг тохиолдуулан суманд үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, 18 иргэн оролцож 2800,0 мянган төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Суманд ажиллаж буй хүнсний дэлгүүр, мухлагуудад худалдаалагдаж буй хүнсний бүтээгдэхүүн, архи согтууруулах ундааны чанар аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг явууллаа. Шалгалтанд 4 аж ахуйн нэгжийн 4 мини маркет, хүнс барааны 1 дэлгүүр, хүнсний 2 мухлаг хамрагдаж, 10 зөрчил илрүүлэн газар дээр нь арилгуулсан.

Хаврын тариалалтанд нөөцөлсөн 12 аж ахуйн нэгж, 6 иргэний 112439 тн улаан буудайн үрнээс дээж авч аймгийн МХГ-т шинжилгээнд хамруулсан.

Тайлант сард шинээр төрсөн 7, гэрлэлтийн бүртгэл 4, эцэг тогтоолт 2, гэрлэлт цуцлалт 3, нас барсны 3, шилжин явсан 4, шилжин ирсэн 9 бүртгэл хийж, иргэний цахим үнэмлэх 9 иргэнд олгож үйлчиллээ.

Нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь олгож ажиллалаа.

### **Шаамар сум:**

XII жарны “Тийн унжлагат” хэмээх Шороон нохой жилийн Хаврын тэргүүн сарын Сар шинийн баярыг тохиолдуулан ахмад настандаа хүндэтгэл үзүүлэх “БУЯНТАЙ БУУРЛУУД 2018” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, суманд ажиллаж амьдарч байсан аж ахуй нэгж, байгууллага нь дампуурсан буюу татан буугдсан, түүнчлэн өөр орон нутгаас шилжин ирснээс харьяалах байгууллага, аж ахуй нэгж байхгүй болсон ахмад настнуудыг сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй ААН-үүдэд хуваарилан харьяалуулж, 8 албан байгууллага, 26 аж ахуй нэгж, хоршоонд 286 ахмад настныг хүлээн авч гарын бэлэг гардууллаа. Мөн 85 ба түүнээс дээш настай 11 ахмад настны судалгааг шинэчлэн гаргаж аймгийн холбогдох дээд байгууллагад хүргүүлж, аймгийн Засаг даргын мэнчдиглээг уламжилж, гарын бэлэг мэндчилгээг өрх гэрт нь хүлээлгэн өглөө. Хүндэтгэлийн арга хэмжээний үеэр 2017 оны ажил үйлсээрээ аймаг, сумаа манлайлж аймгийн “Аварга фермер”-ээр шалгарсан Шаамар сумын “Бал бурам” бүлийн хамт олонд өргөмжлөл, аваргын туузыг гардуулж, сумын Хөдөө аж ахуйн салбар олон жил үр бүтээлтэй ажиллаж эрхэлсэн салбараа манлайлсан дараах иргэдийг шалгаруулж алдаршууллаа.

Сар шинийн баярыг угтан “Шаамарт үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг 2-р сарын 12, 13-ны өдрүүдэд зохион байгуулж, 11 иргэн мах, махан бүтээгдэхүүн, сүү, цагаан идээ, төмс хүнсний ногоо, зөгийн бал, хэвийн боов, гар урлалын болон соёлын бараа зэрэг 10 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр үйлчилгээ үзүүллээ.

Шаамар суманд 2013-2017 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн бүтээн байгуулалтын ажлын мэдээллийг нэгтгэн бэлтгэж, 2018 онд хэрэгжүүлэх Орон нутгийн хөрөнгө оруулалтын сангийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна.

“Төрийн албан хаагчийн Улсын нэгдсэн тоо бүртгэлийн мэдээ”-г хүний нөөцийн шинэ системээр авах болсонтой холбогдуулан сум, тосгоны 13 байгууллагыг хариуцсан нягтлан бодогчдоор нууцын баталгаа гаргуулж, хүний нөөцийн системд нэвтрэх эрхийг баталгаажуулан 2017 оны мэдээ тайланг аймгийн хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэнд цахимаар хүлээлгэн өгч, сумын ЗДТГ-ын 1 сул орон тооны захиалгыг хүргүүлсэн.

Сум хөгжүүлэх сангаас бага оврын трактор, чацарганы суулгац зээлээр авсан иргэдийн зээлийн эргэн төлөлтийн хуваарийг гаргаж, сум хөгжүүлэх сангийн зээлийн хувийн хэргийн бүрдэлтэнд хяналт хийн зээлийн графикайг холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллалаа.

Аймгийн ХХААГ-аас малын 2240 тонн хорголжин тэжээл олгосныг Дэлгэрхаан 1 дүгээр багийн 11 иргэнд 20 шуудай, Охиндий 2 дугаар багийн 6 иргэнд 17 шуудай, Дулаанхаан 3 дугаар багийн 4 иргэнд 7 шуудай хорголжин тэжээлийг тус тус худалдан борлуулсан.

Үндэсний хэмжээнд зохион байгуулагдаж буй "Хуулиа мөрдье-21" аяны хүрээнд сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй "Шонхлой", "Тэнгис", "Оюу", "Тэнгэрлэг", "Дүүрэн", "Соёмбо", "Ундрагч" зэрэг хүнсний дэлгүүрүүдийн худалдагч нарт Архидан согтууруулахтай тэмцэх тухай хуулийн 7, 8 дугаар зүйл заалтыг танилцуулан, 21 нас хүрээгүй хүнд архи согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдахгүй байхыг анхааруулж, ЕББДС, МСҮТ, дэлгүүрүүдийн мэдээллийн самбар болон хэрэглэгчийн буланд аяны плакатыг байршуулсан. Мөн сурагчдыг эерэг хандлагад уриалж, хорт зуршлаас удьдчилан сэргийлэх арга замын талаар сурталчлан таниулах зорилгоор ЕББДС-ын ахлах ангийн сурагчдын дунд "Архины хор хөнөөл" сэдэвт сургалтыг 2-р сарын 01-ний өдөр зохион байгуулж, нийт 20 гаруй сурагчид хамрагдлаа.

Нийгмийн даатгалын сангийн 2018 оны эхний 2 сарын тайлан тэнцлээр 23 ажил олгогч, 196 даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэл төлж, сайн дурын даатгалд шинээр 1 хүн хамруулж нийт 277 даатгуулагчийн шимтгэлийг сар болон улирлаар төлүүлж, нийгмийн даатгалын дэвтэр болон эрүүл мэндийн даатгалын дэвтрийг тухай бүр нь баталгаажуулан ажиллаллаа. Мөн Монгол Улсын Их Хурлаас 2012 онд гаргасан ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн хугацаа дууссан тул хамрагдаагүй төлбөр дутуу 44 иргэний төлбөрийг барагдуулж, орлогын төлөвлөгөө өссөн дүнгээр 21,0 сая төгрөг оруулахаас 19,0 сая төгрөгийг төвлөрүүлсэн.

2018 оны 2 дугаар сарын байдлаар Шаамар сумын 1, 2 дугаар багийн хэмжээнд шинээр төрсөн эрэгтэй 3, эмэгтэй 1 хүүхэд төрж, нийт 4 хүүхэд төрсний гэрчилгээг үнэ төлбөргүй олгосон. Гэрлэлтээ батлуулах хүсэлт гаргасан 2 иргэний бүртгэн гэрчилгээ олгож, нас барсан 2 иргэний нас барсаны бүртгэлийг хийж гэрчилгээг тус тус олгосон. 2018 оны 2 дугаар сарын байдлаар бусад аймаг хотруу шилжин явсан 5 иргэн, бусад аймаг, сумаас 2 иргэн өөрийн хүсэлтийн дагуу шилжин ирсэн.

Сумын ард иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор Нум сумын тэмцээнийг зохион байгуулж, нийт 50 гаруй хүүхдүүд оролцсон. Мөн сумын хэмжээнд анх удаа Бүсийн гар бөмбөгийн тэмцээнийг зохиож, тэмцээнд Цагааннуур, Сүхбаатар сум, Бугант тосгоны багууд оролцлоо.

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН :

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ш.ЭНХМАА

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА

Ө.СУВДАА